

АГУУЛГА

Нэг. Ерөнхий тойм

Хоёр. Байгууллагын үндсэн үйл ажиллагаа

- 2.1 Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд хийсэн ажил
- 2.2 Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, үр дүн
- 2.3 Хууль, дүрэм, журам, төлөвлөгөөний төсөлд санал өгөх талаар
- 2.4 Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд хийсэн ажил
- 2.5 Бусад байгууллагатай хамтран ажиллах хүрээнд
- 2.6 Хүний нөөцийн ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 2.7 Сургалтын ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 2.8 Санхүү төлөвлөлт, аж ахуйн ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 2.9 Албан хэрэг хөтлөлт, өргөдөл гомдол, шийдвэрлэлтийн ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 2.10 Мэдээллийн технологийн чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажил
- 2.11 Байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил

Гурав. Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаа

- 3.1 Иргэний улсын бүртгэл хөтлөх хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 3.2 Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 3.3 Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 3.4 Зөөврийн тоног төхөөрөмж ашиглан улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн байдал
- 3.5 Бичиг баримтжуулах ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 3.6 Улсын бүртгэлийн архивын ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил

Дөрөв. Сонгууль зохион байгуулах ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил

- 4.1 Монгол Улсын Их хурлын 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 4.2 Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил

Тав. Зохион байгуулсан бусад ажил

- 5.1 Зарлан мэдээллийн дохиогоор ажилласан тухай
- 5.2 “Цэвэрлэгээний өдөр” арга хэмжээг зохион байгуулсан тухай
- 5.3 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн зохион байгуулсан тухай
- 5.4 Бусад

Зургаа. Санал.

НИЙСЛЭЛИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ. ЕРӨНХИЙ ТОЙМ

Нийслэлийн улсын бүртгэлийн газар нь нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд төрөөс явуулж буй бүртгэлийн талаарх бодлого чиглэл, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөө, дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэн ажиллаж, хэлтэс, нэгжүүдийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хуульд заасан улсын бүртгэлийн зарим төрлийн үйлчилгээг үзүүлэх гэсэн 2 үндсэн чиг үүргийн хүрээнд Захиргаа удирдлагын хэлтэс /12/, Харилцагчийн үйлчилгээний хэлтэс /4/, Архивын хэлтэс /9/, дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс /395/ гэсэн нэгжүүдтэйгээр нийт 420 ажилтан, албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус газар нь өөрийн харьяа 34 нэгжээс (нийслэл, 9 дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс, нийслэлийн үйлчилгээний нэгдсэн 6 төв, 15 Улсын бүртгэлийн цэг, 3 хурдан цэг) Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон бусад хууль, тогтоомжид заасны дагуу бүртгэлийн үйлчилгээг үзүүлж байна.

Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар нийслэлийн хэмжээнд нийт 1108237 иргэн, хуулийн этгээдэд үзүүлсэн байна.

Одоогоор Хан-Уул дүүргийн “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудал дахь улсын бүртгэлийн үйлчилгээний цэг, Сүхбаатар дүүргийн “Их тойруу” дахь улсын бүртгэлийн үйлчилгээний цэгүүд амралтын өдөр буюу Бямба гарагт тогтмол улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлж байна.

ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1 Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:

Тус газар нь “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.3, “Алсын хараа-2050” зорилт 5.3, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.1, Улсын бүртгэлийн байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний хүрээнд үйл ажиллагаагаа төлөвлөн ажиллаж байна.

Мөн Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2022 оны 5 дугаар сарын 2-ны өдрөөс эхлэн тоон гарын үсэг олгох ажлыг нийслэлийн хэмжээнд дүүргүүдийн улсын бүртгэлийн хэлтэс, нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв, цэгүүдээр олгож байна.

Тайлангийн хугацаанд нийт 43275 иргэнд тоон гарын үсэг олгосон байна.

2.2 Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, үр дүн:

Тайлангийн хугацаанд Засгийн газрын 1 тогтоол, Засгийн газрын 1 хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын 1 албан даалгаврыг хяналтанд авч хэрэгжүүлэн ажиллалаа.

Энэ хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий газраас хүний нөөцтэй холбоотой 227 тушаал, чиглэл 17, зөвлөмж 3, Нийслэлийн Засаг даргын захирамж 8, чиглэл 7, Нийслэлийн архивын газраас 2 чиглэл ирснийг хяналтанд авч, хэрэгжилтийг ханган ажилласан.

2.3 Хууль, дүрэм, журам, төлөвлөгөөний төсөлд санал өгөх талаар:

Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон төрийн бусад байгууллагаас санал авахаар ирүүлсэн 17 хууль, дүрэм, журам, төлөвлөгөөний төслийг албан хаагчдад танилцуулж, саналыг холбогдох газруудад хүргүүлсэн байна.

2.5 Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралд 5, шуурхай хуралдаанд 20, холбогдох ажлын хэсгүүдийн хуралд тухай бүр оролцон өөрт хамаарах 92 үүргийн биелэлтийг тухай бүр гарган хүргүүлсэн.

Нийслэлийн Засаг даргын шуурхай хуралдаанд 20 удаа оролцож 44 үүрэг даалгаварын биелэлтийг 100 хувь ханган хүргүүлсэн.

Өгөгдсөн үүрэг даалгаврын хүрээнд газрын удирдах албан хаагчдын шуурхай хуралдааныг 18 удаа зохион байгуулж, хурлаас нийт 159 үүрэг даалгавар өгч, биелэлтийг ханган ажиллаж байна.

Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын даргын 98 тушаал боловсруулж, батлав.

Тус газрын Захиргаа удирдлагын хэлтсээс 2, Харилцагчийн үйлчилгээний хэлтсээс 1, Архивын хэлтсээс 3 чиглэл нийт 6 чиглэл боловсруулан дүүргүүдийн улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлсэн.

Тус газар нь тайлангийн хугацаанд нийт 123 төрлийн тайлан, мэдээ, санал, судалгааг давхардсан тоогоор 250 гаруй удаа холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

“Хуулийн хэрэгжилт, хамтын ажиллагааг дэмжих жил”-ийн хүрээнд улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандартын хэрэгжилтэд нэгжийн удирдах албан хаагчдын гүйцэтгэж, хэрэгжүүлэх үүрэг, бүртгэлийн үйлчилгээг үзүүлж байгаа албан хаагчдын харилцаа хандлагыг дээшлүүлэх зорилгоор “Стандарттай хамт олон” хэлэлцүүлгийг 2024 оны 01 дүгээр сарын 22, 24-ний өдрүүдэд 2 удаа зохион байгууллаа. Тус хэлэлцүүлэгт газрын албан хаагчид, дүүргүүдийн улсын бүртгэлийн хэлтсийн дарга, улсын ахлах бүртгэгч нар оролцов.


Уулзалтад тус газрын болон дүүргүүдийн улсын бүртгэлийн хэлтсийн 34 удирдах албан тушаалтан хамрагдав.



“Улсын бүртгэлийн үйлчилгээнд өгөгдлийн шинжилгээ хийх ажил”-ын хүрээнд нэгжүүдээс үзүүлсэн иргэний улсын бүртгэлийн үйлчилгээний тоон үзүүлэлт, бүртгэлийн үйлчилгээний төв, цэгүүдээс үзүүлж буй үйлчилгээ, нэр төрөл, үйлчилгээний цонх, ажиллаж байгаа улсын бүртгэгч, төлбөр төлөх нөхцөл, QR код байршуулсан тоо зэргийг задлан судалгаа гарган, дүн шинжилгээ хийв.

Улсын бүртгэлийн байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөнд “Улсын бүртгэлийн үйлчилгээний төв, цэгүүдийн үйл ажиллагааны үр дүн, анхаарах асуудал” сэдвээр танилцуулга хийсэн.





Бусад байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр:

Тус газар өөрийн үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд Сангийн яам, Тагнуулын ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн онцгой байдлын газар, Нийгмийн халамжийн газар, Нийгмийн даатгалын газар, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, “Гэр бүл хүүхэд залуучуудын газар”, Нийслэлийн эрүүл мэндийн төв, Нийслэлийн боловсролын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харьяа баривчлах байр, бүх шатны ерөнхий боловсролын сургуулиуд, хууль хяналтын болон холбогдох төрийн бүх шатны байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Мөн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор “Гэрэгэ системс” ХХК, “Монгол Шуудан” ХХК, “Дэлхийн Зөн” олон улсын байгууллага, “Зөв амьдрах ухаан” төрийн бус байгууллага, “Монгол банк”, “Голомт банк”, “Төрийн банк”, “Богд банк”, “Хаан банк”, “Хас банк” зэрэг байгууллагуудтай хамтран ажиллалаа.

Багануур дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс нь:

- Дүүргийн Иргэдийн хурал, Засаг даргын хөрөнгө оруулалтаар 26,190,000 төгрөгийн үнэ бүхий 4G зөөврийн сүлжээний төхөөрөмж 2ш, иж бүрэн компьютер 5ш, Гэрэгэ киоск машин 2ш, үйлчилгээний заалны ширээний хаалт 9 ширхэгийг тус тус шийдвэрлүүлэн ажилласан.



Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс нь:

- Улсын бүртгэлийн 24/7 цахим машиныг Улсын бүртгэлийн ерөнхий газраас Баянгол дүүргийн харъяа нутаг дэвсгэр болох /27 дугаар хороо/ Улаанбаатар хотын төмөр замын вокзалын зорчигч тээврийн төвийн нэг давхарт байршуулан бүртгэлийн үйлчилгээг үзүүлж байна.
- Дүүргийн Засаг даргын Тамгын газраас зөврийн 2 ширхэг иж бүрэн тоног төхөөрөмж, Баянгол төвийн албан хаагчдын ажлын нөхцөлийг сайжруулах төрийн үйлчилгээний шуурхай байдлыг хангах зорилгоор 20 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмжийг шийдвэрлүүлсэн. Мөн Алтай, Бичил цэгийн үйл ажиллагааг дэмжих үйлчилгээний нөхцөлийг сайжруулахад тус бүр 10 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмжийг шийдвэрлүүлж, засвар үйлчилгээ хийсэн. 4 цэгийн иргэдийн үйлчилгээний бүх сандлуудыг шинэчлэн сольж өгсөн.
- Мөн хэлтсийн 9 албан хаагчдад нийт 25 сая төгрөгийн буцалтгүй тусламж шийдвэрлүүлсэн.

Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс нь:

- Иргэдэд төрийн үйлчилгээг чирэгдэлгүй үйлчлэх ажлын хүрээнд дүүргийн төсвийн хөрөнгөөр 2024 онд нийт 29 улсын бүртгэлийн үйлчилгээний цахим машин (киоск), 29 карт уншигч пос машиныг худалдан авсан. Тус дүүргийн нийт 43 хорооноос 33 хорооны байранд тус бүр 1, дүүргийн Засаг даргын тамгын газрын байранд-2, Улсын бүртгэлийн хэлтсийн байранд-4, Жанжин нэг цэгийн үйлчилгээний байранд-1 нийт 41 улсын бүртгэлийн үйлчилгээний цахим машин (киоск)-ыг байрлуулсан бөгөөд цахим машиныг сүлжээнд холбон, программ суулгаж хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна.
- Улсын бүртгэлийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 24/7 цэгийг хэлтсийн байр болон Дүнжингарав нэг цэгийн үйлчилгээний төвд тус тус нээж, 274 иргэн иргэний үнэмлэх, гадаад паспортын захиалгын үйлчилгээг авсан байна.



Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс нь:


- 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн Сүхбаатар дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Сансар үйлчилгээний төвийн 2 давхарт улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх “Сансар” цэг байгуулан ажиллаж

байна. Тус цэгийг дүүргийн Засаг даргын 2023 оны А/573 дугаар захирамжаар 33.000.000 /гучин гурван сая/ төгрөгийн дэмжлэг авч, үйлчилгээний танхим бүхий 50 м.кв талбайг засаж, тохижуулан, хяналтын улсын байцаагч, улсын ахлах бүртгэгчийн 1 өрөө, хуулийн этгээд, эд хөрөнгийн бүртгэгчийн 1 өрөө, иргэдэд үйлчлэх улсын бүртгэгч нарын үйлчилгээний танхимын зохион байгуулалтыг хийлээ. Өрөө тасалгаанд тохирох ширээ, сандал, тавилгыг захиалгаар хийлгэж, тохижуулан иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх нөхцлийг бүрдүүлсэн бөгөөд хяналтын улсын байцаагч 1, улсын ахлах бүртгэгч 1, иргэний улсын бүртгэгч 2, эд хөрөнгийн улсын бүртгэгч 2, хуулийн этгээдийн улсын бүртгэгч 1 тус тус ажиллаж байна.



Сонгинохайрхан дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс нь:

- Улсын төсвийн хөрөнгөөр хэлтсийн байр барих газарт Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын 2024 оны 5 сарын 3-ны А/498 дугаар захирамжаар газар эзэмших эрхийн гэрчилгээ авсан. Сонгинохайрхан дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Архив, улсын бүртгэлийн албан конторын барилгын зураг төслийг “ББСМО” ХХК-аар гүйцэтгүүлж, Хот байгуулалт, хотын стандартын газраар батлуулж, барилга барих ажлын даалгаврыг гаргуулсан. Улаанбаатар дулааны сүлжээ ХХК, Мэдээлэл холбооны сүлжээ ХХК, Улаанбаатар хотын ус сувгийн удирдах газар, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ХХК-д холбогдох техникийн нөхцөлийг гаргуулахаар тус тус албан тоотыг хүргүүлсэн. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын ерөнхий архитекторын “Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын Архив, улсын бүртгэлийн хэлтсийн цогцолбор барилга”-ын архитектур төлөвлөлтийн даалгавар батлагдсан. “Лэнд тест” ХХК-ийн Архив, улсын бүртгэлийн хэлтсийн цогцолбор байр барих барилгын талбайн инженер-геологийн судалгааны дүгнэлт гарсан. Ус сувгийн удирдах газрын Техникийн нөхцөл олгох комиссын 2024 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн хурлын шийдвэрээр техникийн нөхцөл батлагдсан.
- Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүртээмжтэй, чирэгдэлгүй хүргэх ажлын хүрээнд 1 дүгээр хорооллын арын зам дагуу байршиж байсан Өнөр цэгийг 16 дугаар хорооны шинэ байр луу нүүлгэж, улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж эхэллээ.



Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс нь:



- Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран нэг цонхны үйлчилгээний танхимын үүдний хэсгийг тохижуулан 24/7 цахим үйлчилгээг нэвтрүүлсэн бөгөөд иргэд гадаад паспорт, иргэний үнэмлэх захиалах, иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг цагийн хязгаарлалтгүй авч байна. Чингэлтэй дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн улсын ахлах бүртгэгч, улсын бүртгэгч нар хуваарийн дагуу төвийн үйл ажиллагааг тодотгосон хэвлэл бүхий поло фудволкаар жигдрэн иргэдэд зөвлөгөө мэдээлэл, тусламж үзүүлэн төвийн хэвийн доголдолгүй үйл ажиллагааг ханган ажилласан. Тус хэлтэс нь төвийн үйл ажиллагааг иргэдэд таниулан сурталчлах зорилгоор өдөр тутмын “Өглөөний сонин”, Zindaa.mn сайтаар мэдээлэл өгсөн.
- Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын хөрөнгө оруулалтаар 416,780,000 төгрөгийн санхүүжилтыг шийдвэрлүүлж, дараахь ажлуудыг гүйцэтгэсэн байна. Үүнд: “Сэлбэ дэд төв”-д 318,780,000 төгрөгийн үнэ бүхий гадаад паспорт захиалгын машин, улсын бүртгэлийн “Дөт” цахим машиныг шийдвэрлүүлж, тус дүүргийн 14 цэгт байршуулан иргэдэд үйлчилгээ үзүүлж байна. Мөн 60,000,000 төгрөгийн иж бүрэн 11 ширхэг компьютер, 11 ширхэг 3 үйлдэлт принтер, 6,000,000 төгрөгийн өрөөний болон танхимын тохижуулалтад хяналтын улсын байцаагч нарын ажлын ширээ болон уулзалтын ширээ, 3 цэгийн улсын ахлах бүртгэгч нарт ширээ, шкаф, хүлээлгийн сандлыг шинээр шийдүүлж, ажиллах орчныг сайжруулсан.



Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас албан хэрэгцээнд зориулж 31,875,000 төгрөгийн үнэ бүхий Хьюндай Соната-7 маркийн автомашиныг шийдвэрлүүлсэн байна.

Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс нь:

- Тус хэлтсийн улсын бүртгэлийн үйлчилгээний “Академи” цэг нь 18 дугаар хорооны иргэний танхимд ажиллаж байсныг албан хаагчдын ажиллах орчин сайжруулах, үйлчилгээний чанарын сайжруулах үүднээс шинээр ашиглалтад орсон 15 дугаар хорооны байр руу нүүлгэн шилжүүлж 6 дугаар сарын 3-ны өдрөөс Хан-Уул дүүргийн Зайсан, Төв цэнгэлдэх бүсийн 11, 15, 17, 18, 19, 22 дугаар хорооны иргэдэд улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэхээр ажиллаж эхэллээ. Ингэснээр үйлчилгээний талбай 40мк-аар нэмэгдэж, албан хаагчдын ажлын байр сайжирсан.



- Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газраас 78 сая 250 мянган төгрөгийн үнэ бүхий иж бүрэн компьютер 7ш, гурван үйлдэлт скайнер 3ш, скайнер 1ш, принтер 3ш, скайнер 1ш, үйлчилгээний танхимын тек /ширээ/ 10ш, шүүгээ 10, шилэн нүүртэй шкаф 10ш, сандал 10ш, хүлээлгийн сандал 14ш, проктер 1ш тоног төхөөрөмж, эд хогшлийг шийдвэрлүүлж, хүлээн авсан.
- Мөн дүүргийн Засаг даргад хүсэлт тавьсаны үндсэн дээр 11 албан хаагчийг Япон улс руу туршлага солилцох ажлын бүрэлдэхүүнд хамруулан явуулсан.
- Иргэн, хуулийн этгээдэд улсын бүртгэлтэй холбоотой лавлагаа, мэдээлэлийг цахим үйлчилгээний нэгдсэн портал E-MONGOLIA.MN болон E-BUSINESS.MN сайт болон ТҮЦ машин, улсын бүртгэлийн байгууллагын цахим “ДӨТ” машинаас, гадаад паспорт захиалах 24/7 машиныг Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар байршуулан харилцагч өөрөө өөртөө үйлчлэн бүртгэл хийлгэх боломжийг олгон ажиллаж байна.

2.6. Хүний нөөцийн чиглэлээр:

Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгон албан хаагчийг томилох, тушаал дэвшүүлэх, чөлөөлөх, сахилгын шийтгэл ногдуулах, шагнаж урамшуулах асуудлыг шийдвэрлэж ажиллалаа.

Хүний нөөцийн чиглэлээр газрын даргын 73 тушаал шийдвэр гарсан.

2023 оны ХАСХОМ-ийг 352 төрийн захиргааны албан хаагчаас хуулийн хугацаанд буюу 2024 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор шинэчлэн гаргуулж баталгаажуулсан.

2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар 79 албан хаагч шинээр томилогдсон, 15 албан хаагч их хэмжээний өөрчлөлт мэдүүлж, ХАСХОМ-д баталгаажуулсан.

Тайлангийн хугацаанд хүний нөөцийн чиглэлээр нийт 24 санал, судалгаа боловсруулж, холбогдох газарт хүргүүлжээ.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 227 тушаалыг хүлээн авч, холбогдох хэлтэст хүргүүлэн хэрэгжүүлж, хяналт тавин ажиллаж байна.

Үндэсний их баяр наадам тохиолдуулан Улсын бүртгэлийн ерөнхий газарт төрийн захиргааны тангараг өргөх 17 албан хаагчийн судалгааг хүргүүлж тангараг өргүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоол, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны Б/218, Б/222 дугаар тушаалын дагуу цалинд өөрчлөлт оруулан, 441 хүнтэй “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим санг эрхлэн хөтөлж өөрчлөлтийг тухай бүр хийж байна.

Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 21 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв шинээр болон ахиулан олгосон албан хаагчдад зэрэг дэвийн нэмэгдлийг системд өөрчлөлт оруулан, олгож байна. Нийгмийн даатгалын байгууллага ажил мэргэжлийн код, даатгуулагчийн төрөл, кодыг өөрчилсөнтэй холбоотой өөрчлөлтийг системд оруулсан. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны А/164 дугаар тушаалаар 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс бүх албан хаагчдын хоол унааны нөхөх олговрыг нэг өдрийн 25000 төгрөг байхаар шинэчлэн тогтоосныг системд оруулж бүртгэсэн.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны гишүүнээр тус газрыг төлөөлөн ажиллах албан хаагчийг сонгох санал асуулгыг Google Roll ашиглан 5 дугаар сарын 1, 2-ны өдрүүдэд 2 шаттайгаар зохион байгуулж, хамгийн олон санал авсан ажилтны нэрийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газарт хүргүүлсэн. Ёс зүйн дэд хороонд Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам”-ын төсөлд санал, Улсын бүртгэлийн байгууллагын соёл, ёс зүйн үнэт зүйлийг тодорхой судалгааны үр дүнгийн дагуу сайжруулах, цаашид авах арга хэмжээний санал, “Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим, хэм хэмжээ” цахим гарын авлага бэлтгэн Улсын бүртгэлийн ерөнхий газрын пэйж хуудсанд байршуулсан.

Газрын даргын 2024 оны А/10 дугаар тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэй албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний баг байгуулан ажиллаж албан хаагчдын эхний хагас жилийн ажлыг үнэлснийг баталгаажуулсан.

Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээг мэдээлэх хуудасны дагуу байгууллагын веб хуудсаар нээлттэй мэдээлж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Үнэлгээний багийн нарийн бичгийн даргад үнэлгээний нэгтгэлийг хүргүүлсэн.

Албан хаагчдыг үнэлэхтэй холбоотой үүссэн материалаар хадгаламжийн нэгж бүрдүүлэн үдэж хавтасласан. Үнэлгээний багийн гишүүдээс үнэлгээний явцад гарсан алдаа дутагдлыг арилгах, албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг хангуулах

чиглэлээр авч хэрэгжүүлэх санал, зөвлөмж гарган хэлтсүүдэд албан бичгээр хүргүүлсэн.

Төрийн захиргааны албан хаагчдын үнэлгээний хуудасны 1 хувийг Улсын бүртгэлийн ерөнхий газар (хувийн хэрэгт оруулах)-т, 1 хувийг албан хаагч (дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс)-д хүргүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Газрын даргын 2024 оны А/25 дугаар тушаалаар албан хаагчдын 2024 оны ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний баг байгуулан ажиллаж байна.

Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиглэлээр:

Улсын бүртгэлийн байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын дагуу ар гэрт гачигдал тохиолдсон, гэр бүлд нь шинээр хүүхэд мэндэлсэн 14 албан хаагчид 100000-660000 төгрөгийн, нийт 8352000 төгрөгийн тусламж үзүүлсэн байна. Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган тус газрын Багануур, Багахангай, Налайх дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн 24 албан хаагчдад урамшуулал олгосон. 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн Б/70 дугаар тушаалаар Баянзүрх дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн хуулийн этгээдийн улсын бүртгэгч Т.Чинарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асрахад нь зориулж 1 цагийн завсарлага нэмж олгосон.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 579 дугаар тушаалаар тус газрын хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 11 албан хаагчид 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тусламж 1 удаа олгосон.

Тус газраас өндөр насны тэтгэвэрт гарсан 45 ахмадын судалгааг гарган Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлсэн. Сар шинийн баярыг тохиолдуулан улсын бүртгэлийн байгууллагын удирдлагууд ахмадуудаа хүлээн авч хүн нэг бүрт цаг тооны бичиг, мөнгөн тусламж үзүүлсэн.

Багахангай 1, Сүхбаатар 30, Хан-Уул 7, Чингэлтэй дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн 14, нийт 52 албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилсан үзлэг хийлгэн өдрийн эмчилгээнд хамруулсан.

Тус газрын хөгжлийн бэрхшээлтэй 21 албан хаагчдын мэдээллийг “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим санд бүртгэсэн. Хөгжлийн бэрхшээлтэй албан хаагчдын нийгмийн баталгааг хангаж, дэмжих ажлын хүрээнд Баянгол дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Г.Содгэрэлд дүүргийн Засаг даргаас мөнгөн тусламж олгуулсан. Тойргийн системээр ажиллах үед хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асардаг албан хаагчийг гэртэй нь ойр ажиллуулах хуваарь хийж ажиллаж байна.

Багануур дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн хамт олон 2024 оны 01 дүгээр сарын 20-нд “Эрүүл агаар-Идэвхтэй хөдөлгөөн” сэдэвт дүүргийн цасны баярын арга хэмжээнд оролцсон. Мөн “Олон улсын гэр бүлийн өдөр”-ийг тохиолдуулан хэлтсийн албан хаагчид тэдний гэр бүлийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамт олны дулаан уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор волейболын тэмцээнийг 5 сарын 20-ны өдөр зохион байгуулж, 1, 2-р байр эзэлсэн.

Чингэлтэй дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс өөрсдийн нөөц боломжиндоо тулгуурлан хэлтсийн 103 болон 104 тоот өрөөний завсрын хэсгийг хүүхдийн өрөө болон албан хаагчдын өдрийн цай уух хэсэг болгох бэлтгэл ажлыг хийж байна.

Тус газрын албан хаагчид “Улаанбаатар марафон 2024” арга хэмжээнд оролцсон.

Тус газрын даргын 2024 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн А/08 тоот тушаалаар эцэг, эхийн зөвлөлийг шинэчлэн байгуулсан. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, Эх үрсийн баярыг тохиолдуулан байгууллагын Эцэг эхийн зөвлөлөөс гар зургийн уралдаан албан хаагчдын хүүхдүүдийн дунд нас насны ангиллаар “Чөлөөт сэдэв” бүтээл, “Миний дуртай ажил” сэдэвт гар зургийн уралдаан, “Инээмсэглэл” сэдэвт зохион бичлэг, “Гэр бүлдээ баярлалаа”, “Ухаарал” сэдэвт захидлын уралдааныг зарлан эхний 3 байрыг шалгаруулж шагнаж урамшууллаа. Уралдааны шагналыг Захиргаа удирдлагын хэлтэс Индранил шүдний эмнэлэгтэй хамтран шийдвэрлэсэн.



2.7 Сургалтын ажлын хүрээнд:

“Нийслэлийн улсын бүртгэлийн газрын сургалтын төлөвлөгөө”-г баталж, 111 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 3102 ажилтан, албан хаагч хамруулсан. /давхардсан тоогоор/

- ❖ Улсын бүртгэлийн ерөнхий газраас 24 удаагийн сургалтаар 942,
- ❖ Нийслэлийн улсын бүртгэлийн газраас 10 удаагийн сургалтаар 760,
- ❖ Дүүргийн улсын бүртгэлийн хэлтсүүд 31 удаагийн сургалтаар 723,
- ❖ Бусад төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулсан 46 удаагийн сургалтанд 677 ажилтан, албан хаагчдыг тус тус хамруулсан байна.

Харилцагчдад зориулан 10 удаагийн сургалтаар 428 харилцагчдад мэдээлэл өгсөн байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын зардлаар төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад нийт 7 албан хаагч Удирдлагын академид амжилттай суралцаж төгссөн.

Улсын бүртгэлийн ерөнхий газар, Азийн хөгжлийн банктай хамтран Улсын бүртгэлийн байгууллагын удирдах албан хаагчдыг гадаад улсад туршлага судлуулах, чадавхижуулах сургалтанд тус газрын дарга, хэлтсийн дарга нарын нийт 12 албан хаагч Бүгд найрамдах Солонгос улсад “Шүүх байгууллагын албан хаагчдын сургалтын төвд” эд хөрөнгийн улсын бүртгэлийн цахимжуулалтын сургалтанд хамрагдсан.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас олгосон квотын дагуу БНХАУ-ын Худалдааны яамны тэтгэлгээр Шанхай хотын Бизнесийн Сургуулиас зохион байгуулсан “Хөгжиж буй орнуудын жижиг дунд үйлдвэрлэлийн чадавхийг

бэхжүүлэх нь” 14 хоногийн сургалт, семинарт 8 дугаар сарын 6-21-ний өдрийн хооронд 1 албан хаагч хамрагдсан.

2.8 Санхүү, аж ахуйн чиглэлээр:

Газрын нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Олон улсын стандартад нийцүүлэн батлагдсан маягт зааврын дагуу хөтлөх, газрын болон дүүргүүдийн улсын бүртгэлийн хэлтсийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлэх, байгууллагын үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх чиг үүргийн хүрээнд ажиллаж байна.

2023 оны Санхүүгийн тайланд гурвалсан гэрээний дагуу “Ниямазон Аудит” ХХК нь төсвийн гүйцэтгэлийн аудит хийж “Өөрчлөлтгүй дүгнэлт” авсан. Аудитын дүгнэлтийг байгууллагын сайт болон шилэн дансанд байршуулсан.

Хууль зүй дотоод хэргийн яам Санхүүгийн нэгдсэн e-accounting программ нэвтрүүлж эхэлж буйтай холбогдуулан нягтлан бодогчид, нийслэл болон дүүргүүдийн няравууд 4 дүгээр сарын 24-26-ны өдрүүдэд сургалтад хамрагдаж, 2023 оны Санхүүгийн тайлангийн эцсийн үлдэгдэл, гүйлгээ, үндсэн хөрөнгө болон бараа материалыг нэр төрөл, эд хариуцагч нараар тус тус хөрвүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:

- ❖ Байгууллагын 2024 оны хагас жил, 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гаргаж Улсын бүртгэлийн ерөнхий газарт;
- ❖ Нийгмийн даатгал, хүн амын орлогын албан татвар, улсын тэмдэгтийн хураамжийн тайлан;
- ❖ Санхүүгийн тайлангийн 2023 оны аудитын тайланд өгсөн зөвлөмжийн мөрөөр төлөвлөгөө гарган батлуулж, хэрэгжилтийн тайланг fas.audit.mn;
- ❖ Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган мэдээллийг цаг хугацаанд нь;
- ❖ Сангийн сайдын тайлан, мэдээ гаргах тушаалын дагуу сар бүр төсвийн гүйцэтгэл, өр авлагын мэдээ;
- ❖ Улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын мэдээг гаргаж Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийслэлийн төрийн санд сар бүрийн 2-нд;
- ❖ Улсын бүртгэлийн ерөнхий газрын Бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний газраас хийсэн шалгалтын зөвлөмжийн дагуу дүүргүүдийн улсын бүртгэлийн хэлтэст ажил сайжруулах чиглэлийг албан тоотоор хүргүүлж, тус тус хэрэгжилтийг ханган ажилласан.
- ❖ Дүүргийн улсын бүртгэлийн хэлтсүүдийн элэгдлээрээ анхны өртөгөө нөхөж ашиглалтын хугацаа дууссан болон эвдэрч гэмтсэн цаашид ашиглах боломжгүй хөрөнгийн судалгааг гаргуулан нэгтгэж актлах шаардлагатай хөрөнгүүдийг татаж авсан бөгөөд Нийслэлийн өмчийн харилцааны газарт жагсаалтыг хүргүүлсэн.

Байгууллагын хэвийн үйл ажиллагааг тасалдалгүй ханган ажиллах хүрээнд:

Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж төсвийг үр бүтээлтэй зарцуулах, хуваарилах, төлөвлөх ажлыг хийж гүйцэтгэсний үр дүнд төсөв дүн хэтрээгүй хэмнэлттэй ажиллаж байна.

Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах саналыг сар бүр Улсын бүртгэлийн ерөнхий газрын Санхүүгийн хэлтэст хүргүүлж, шинээр үүссэн өр авлагагүй ажилласан.

Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг тогтмол төвлөрүүлж, улсын төсөвт төвлөрүүлсэн үйлчилгээний орлого болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх хүү, торгуулийн орлогын мэдээг сар бүр гарган хүргүүлж тооцоо нийлж байна.

Улсын төсөв, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн орлогын талаар:

2024 оны 10 сарын байдлаар дараах орлогыг төвлөрүүлэн ажилласан байна.

Д/д	Хугацаа	Орлого, зардлын зүйл анги	Үйлчилгээний төрөл	Мөнгөн дүн /өссөн дүнгээр/
1	2024 оны 10 дугаар сарын 31-ний байдлаар	Улсын төсөвт	Үйлчилгээний орлого	12.3 тэрбум
2		Орон нутгийн төсөв	Торгууль шийтгэврийн орлого	858.0 сая
			Тэмдэгтийн хураамж	3.9 тэрбум
			Үл хөдлөх хөрөнгийн татвар	88.3 тэрбум

Худалдан авах ажиллагааны талаар: 2024 оны батлагдсан төсвийн хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу “Бичиг хэргийн материал” худалдан авах цахим нээлттэй тендер шалгаруулалтыг явуулсан.

Үндсэн хөрөнгө, бараа материалын орлогыг үнэн зөв хүлээн авч зарцуулалтанд хяналт тавьж ажиллалаа.

Үндсэн хөрөнгийн орлого: Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын төсвийн хөрөнгө оруулалтаар 39.6 сая төгрөгний үнэ бүхий 2 ширхэг зөөврийн компьютер, 16 ширхэг принтер, Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын төсвийн хөрөнгө оруулалтаар 855.6 сая төгрөгийн киоск машин 33 ширхэг, шуурхай карт хэвлэх машин 1 ширхэг, дэлгэц 1 ширхэг, Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газраас 78.7 сая төгрөгний машин тоног төхөөрөмж болон эд хогшил, Чингэлтэй дүүргийн Иргэдийн төлөөгчдийн хурлын 66 дугаар тогтоолоор 51.6 сая төгрөгийн компьютер, принтер, нийт 1,035.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг тус газрын даргын тушаалаар данс бүртгэлд тусган ажилласан.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын <http://burtgel.pcsp.gov.mn/> үндсэн хөрөнгийн тооллогын программд 2023 оны жилийн эцсийн байдлаар хөрөнгийг хугацаанд нь шивж оруулан нэгтгүүлсэн. Мөн Нийслэлийн өмчийн харилцааны газартай өмч эзэмших гэрээг шинээр байгуулсан.

Цалин хөлсний талаар: Тус газрын даргын 2024 оны А/18 дугаар тушаалаар “Нийслэлийн улсын бүртгэлийн газрын ажлын цаг ашиглалтын журам”, А/19 дугаар тушаалаар “Нийслэлийн улсын бүртгэлийн газрын цалин хөлсний журам”-ыг тус тус батлан мөрдөн ажиллаж байна.

Монгол улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолын дагуу албан хаагчдын цалинг шинэчлэн тогтоож хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

/сая.төгрөг/

<i>Д/д</i>	<i>Үзүүлэлт</i>	<i>Батлагдсан төсөв</i>	<i>Зарцуулах эрх</i>	<i>Гүйцэтгэл</i>
1	Цалин хөлс	9,426.5	9,426.5	8,730.9
2	НДШ	1,166.1	1,166.1	1,037.2
3	Нийт	10,592.6	10,592.6	9,768.1

Үнэт цаасны талаар: Улсын бүртгэлийн ерөнхий газраас 15 нэр төрлийн 422,806.7 мянган төгрөгийн үнэт цаас хүлээн авч хэлтсүүдэд хуваарилсан. Гэрчилгээ, үнэт цаасны зарцуулалтад сар бүр тогтсон хугацаанд хяналт тавин ажиллаж байна.

2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар улсын бүртгэгч болон техникийн алдаанаас шалтгаалан акталсан 3266 ширхэг 2127.9 мянган төгрөгийн үнэт цаасыг өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар оруулахаар бэлтгэн ажиллаж байна. Үүнээс 2611 ширхэг нь ажилтны алдаа, 655 ширхэг нь техникийн алдаа гарсан байна. Алдаа гаргасан ажилтнуудаар 1,714.8 мянган төгрөгийн төлбөрийг бүрэн төлүүлсэн.

Сонгуультай холбоотой ажлын талаар: 2024 оны Улсын Их Хурлын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн бэлтгэл ажилд шаардлагатай бичиг хэрэг, тоног төхөөрөмж, тээвэрлэлт, томиллолт, сургалтын зардлуудыг дүүргийн улсын бүртгэлийн хэлтсүүдэд хуваарилан ажилласан. Мөн сонгуулиар ажилласан итгэмжлэгдсэн ажилтан болон улсын бүртгэлийн ажилтнуудад батлагдсан төсөвт багтаан урамшуулал олгосон.

Бусад ажлын талаар: Дүүргийн улсын бүртгэлийн хэлтсүүдээс ирсэн албан бичгийн дагуу Сонгинохайрхан дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн заалны камерийн сэлбэг, Налайх дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн 2 суурин компьютерийн сэлбэг хэрэгсэл, Хан-Уул дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн архивын нүүлгэлтийн шатахууны зардал, Багахангай дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн гадна, дотор хаалганы зардал, Сүхбаатар, Сонгинохайрхан дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн сүлжээний кабель, мөн Сүхбаатар дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн нэг цонхны үйлчилгээний шил хагарсныг солих зардлыг тус тус шийдвэрлэж ажилласан.

Явцын аудит хийлгэхээр “Ниямазон Аудит” ХХК-д эхний 9 сараар санхүүгийн анхан шатны баримтууд болон харилцахын баримтуудаа хүлээлгэн өгсөн.

2.9 Албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдол, шийдвэрлэлтийн ажлын хүрээнд:

2.9.1 Албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр:

Тайлангийн хугацаанд 14216 албан бичиг хүлээн авч edoc програмд бүртгэснээс хариутай бичиг 4005, хариугүй албан бичиг 10211 байна. Албан бичгийн шийдвэрлэлтэд тогтмол хяналт тавьж ажиллаж байгаа бөгөөд шийдвэрлэлтийн дундаж хугацаа 4 хоног 3 цаг 4 минут байна. Ирсэн бичгийн шийдвэрлэлт 97.8%-тай байна.

Мөн edoc болон цаасаар 7611 албан бичиг явуулсан. Нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудад архив, албан хэрэг хөтлөлтийн програмаар илгээж бусад албан бичгүүдийг шуудангаар холбогдох газарт нь хүргүүлэн ажиллаж байна.

Тус газрын 2024 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулан батлуулж, 2023 хөтлөгдсөн баримт бичгийг Архивын тухай хуулийн дагуу байгууллагын архивт 2023 оны 1 дүгээр улиралд хүлээн авсан.

ERP системд албан бичиг боловсруулах цэсэд орсон өөрчлөлтийг албан хаагчдад танилцуулж сургалт хийсэн.

2.9.2 Өргөдөл, гомдол, шийдвэрлэлтийн ажлын хүрээнд:

Тус газар нь иргэн, хуулийн этгээдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг бүх талаас нь нягтлан судалж, хууль зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэж, хуулийн хугацаанд хариу өгөх жишиг тогтоох үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллаж байна.

Мөн иргэн хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл гомдол, санал, хүсэлтийн шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийж, сайжруулалтын арга хэмжээ авч ажиллав.

Тус газарт 2023 оны 12 дугаар сарын 26-наас 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрүүдэд иргэн, хуулийн этгээдээс 399 санал хүсэлт, талархал, гомдол, ирсэн байна.

/Талархал – 83 буюу 21%, Хүсэлт, санал – 64 буюу 16%, Гомдол – 252 буюу 63%/

Санал хүсэлт, талархал, гомдлын эзлэх хувь: /Хэлтэс тус бүрээр/

№	Дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн нэр	Санал, хүсэлт		Талархал		гомдол		Нийт	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Багануур	0	0%	2	0,5%	0	0%	2	0,5%
2	Багахангай	0	0%	3	0,75%	1	0,25%	4	1%
3	Баянгол	7	1,75%	8	2%	23	6%	38	10%
4	Баянзүрх	16	4%	8	2%	84	21%	108	27%
5	Налайх	1	0,25%	0	0%	2	0,5%	3	0,8%
6	Сонгинохайрхан	7	2%	15	3 %	23	6%	45	11%
7	Сүхбаатар	9	2,5%	16	4%	24	7%	49	12,2%
8	Хан-Уул	22	5%	16	4%	56	14%	94	23,5%
9	Чингэлтэй	1	0,25%	14	3,5%	34	8%	49	12%
10	Нийслэл	1	0,25%	1	0,25%	5	1,25%	7	2%
	Нийт	64	16%	83	21%	252	63%	399	100%

Санал хүсэлт, талархал, гомдол ирүүлсэн суваг, эзлэх хувь:

№	Ирүүлсэн суваг	Тоо	Хувь
1	ЗГ 11 – 11	310	78%
2	1800 – 1200	48	12%

3	ННЗБ	36	9%
4	Цахим	5	1%
	Нийт	399	100%

Санал хүсэлт, талархал, гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацаа:

№	Нэгж	Шийдвэрлэлтийн дундаж хугацаа	Тоо
1	Багануур дүүргийн УБХ	2х 7ц 8 минут	2
2	Багахангай дүүргийн УБХ	2х 22ц 34минут	4
3	Баянгол дүүргийн УБХ	3х 3ц 59минут	38
4	Баянзүрх дүүргийн УБХ	4х 11ц 16минут	108
5	Налайх дүүргийн УБХ	2х 21ц 16минут	3
6	Сонгинохайрхан дүүргийн УБХ	5х 00ц 20минут	45
7	Сүхбаатар дүүргийн УБХ	3х 19ц 9минут	49
8	Хан-Уул дүүргийн УБХ	2х 00ц 6минут	94
9	Чингэлтэй дүүргийн УБХ	4х 5ц 48минут	49
10	Нийслэлийн УБГ	2х 13ц 52минут	7
	Нийт дундаж	3 хоног 10 цаг 27 минут	399

Нийт 399 санал хүсэлт, талархал, гомдол ирсэн байх бөгөөд хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл гомдол байхгүй 100 хувь шийдвэрлэсэн.

Иргэн хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл гомдол

Тайлангийн хугацаанд иргэн, хуулийн этгээдээс тус газрын үйл ажиллагаа, албан хаагчдын харилцаа, хандлага зэрэгтэй холбоотой нийт 252 өргөдөл гомдол ирсэн байх бөгөөд эдгээрийг холбогдох харьяалал болон агуулгаар нь ангилж харуулбал:

д/д	Агуулга	Тоо	Хувь
1	Байгууллагын зохион байгуулалттай болон хүний нөөцтэй холбоотой	35	14%
2	Албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлагатай холбоотой	54	21,5%
3	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой	59	23,5%
4	Иргэний улсын бүртгэлтэй холбоотой	76	30%
5	Хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой	8	3%
6	Сүлжээ тасарсантай холбоотой	9	4%
7	Үйлчилгээний хураамж болон буцаалттай холбоотой	3	1%
8	Хамааралгүй /Бусад/	8	3%
	Нийт	252	100%

Тайлангийн хугацаанд өргөдөл, гомдлын тайланг сар, улирал, хагас жилээр гаргаж, нэгдсэн дүгнэлт хийж сайжруулалтын арга хэмжээ авч ажиллав.

2.10. Мэдээллийн технологийн чиглэлээр:

Газрын тоног төхөөрөмж, сүлжээний хэвийн үйл ажиллагааг хангах, ашиглалтад хяналт тавих, мэдээллийн нэгдсэн сангийн хадгалалт, хамгаалалт, бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй системүүдийн хэвийн найдвартай ажиллагааг ханган ажиллаж байна.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын системээр хүний нөөцийн удирдлага, утасны жагсаалт, цаг бүртгэл, мэдээ мэдээлэл, ажлын хэсэг, хурал, уулзалт, үүрэг даалгавар, олон нийтийн сүлжээ, тайлан судалгаа, өргөдөл гомдол, үндсэн хөрөнгө бүртгэл, үйл явдал, судалгаа авах, байгууллагын архив, албан хэрэг хөтлөх, дотоод мессенжер зэрэг өргөн боломжтой цогц системийг албан хаагч нарт хандах эрхийг тохируулан ажиллаж байна. Тус газрын программ болон сүлжээний аюулгүй байдал техник хангамжийн аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

Албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг сайжруулах зорилгоор ажлын цаг бүртгэлийн цахим програмыг өөрсдийн дотоод нөөц бололцоогоо ашиглан хийж, хяналт тавин ажиллаж байна.

2.11. Байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах сурталчилах ажлын хүрээнд:

2.11.1 Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал

Байгууллагын ил тод нээлттэй, шуурхай хариуцлагатай байдлыг хангаж, төр иргэний харилцан итгэлцлийг бэхжүүлэх зорилгоор байгууллагынхаа үйл ажиллагааг сурталчилж мэдээлэх, иргэдийн санал бодлыг сонсох, “Нээлттэй хаалганы өдөр”, бүртгэлийн “Ёслолтой арга хэмжээ”, иргэдэд чиглэсэн бусад үйл ажиллагааг тогтмол зохион байгуулан үйл ажиллагааны төлөвлөгөөндөө ил тод, нээлттэй, хариуцлагатай, хүнд сурталгүй, авлигаас ангид төрийн үйлчилгээг төлөвшүүлэх зорилтуудыг тусган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

- ❖ Монгол Улсын Засгийн газрын 352 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Нээлттэй мэдээллийн ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ын дагуу байгууллагын эрхэм зорилго, тэргүүлэх чиглэл болон байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журам, заавар, төр засгийн бодлого шийдвэртэй холбогдсон мэдээ, мэдээллийг “Мэдээллийн самбар”, цахим дэлгэц, байгууллагын болон хэлтэс нэгжийн цахим хуудас, фэйсбүүк хуудсанд бүрэн байршуулж, мэдээллийг тухай бүрт шинэчлэн ойлгомжтой байдлаар байршуулсан.
- ❖ Байгууллагын хэмжээнд иргэдийг цагийн хуваарьгүйгээр хүлээн авч, санал хүсэлтийг шийдвэрлэн ажиллаж байна. Газрын нийт албан хаагчид болон


өргөдөл, гомдол хүлээн авах ажилтны мэдээллийг газрын цахим хуудсанд нээлттэй байршуулсан.

- ❖ Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, газрын төсөв санхүү, орлого, зарлагын гүйлгээний 139 мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбараар дамжуулан олон нийтэд мэдээлсэн.


Байгууллагын албан ёсны цахим хуудас болон нүүр номоор сурталчилсан байдал:

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн мэдээ мэдээлэл болон хуулиар хориглоогүй аливаа мэдээллийг бүхий л арга хэлбэрээр шуурхай хүргэхийн зэрэгцээ бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааг сурталчлах ажлын хүрээнд:

- ❖ Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, газрын төсөв санхүү, орлого, зарлагын гүйлгээний 139 мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбараар дамжуулан олон нийтэд мэдээлсэн.
- ❖ Байгууллагын үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилах ажлын хүрээнд 22 удаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэн, хуулийн этгээдэд улсын бүртгэлийн үйлчилгээтэй холбоотой мэдээлэл өгч, тэдний эрх зүйн боловсролыг дээшлүүлэн ажилласан байна. Тухайлбал: Улсын бүртгэлийн үйлчилгээг харьяалал харгалзахгүй хүртээмжтэй үзүүлдэг болсон, шилжилт хөдөлгөөний бүртгэл түр зогсохтой холбоотой, мөн нийслэлийн хэмжээнд улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлж буй цэгүүдийн талаар “VIP 76” сайт, Нэгүүн.мн, Мэдээ.мн, Улаанбаатар.мн, Тэнцвэр.мн сайтуудад газрын дарга Г.Анхныбаяр 3 удаа ярилцлага өгч иргэн, хуулийн этгээдийг мэдээ, мэдээллээр хангаж ажиллав.




- ❖ Нийслэлийн дүүргийн улсын бүртгэлийн хэлтсүүдээс “UBS”, “МҮОНР”, “ТВ-9”, “С1”, “ТВ-5”, “Толь мэдээ”, “Масс”, “Багануур” телевиз, Баянгол, Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэвлэл мэдээлэлд, “Зариг.мн”, “Ivoice”, Налайх мэдээ” сайтад 19 удаа ярилцлага өгч иргэн, эд хөрөнгийн эрхийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн талаар, шинээр байгуулагдсан үйлчилгээний цэгүүд, 24/7 үйлчилгээ, бичиг баримтжуулах аян, electoin.burtgel.gov.mn сайтаар нэвтэрч өөрийн мэдээлэл, сонгууль өгөх байршлаа харах боломжтой зэргээр сурталчилж, мэдээ мэдээлэл өгч ажиллав.



- Тус газрын 7777-1890 тусгай дугаарын утсаар 1478 иргэн, хуулийн этгээдийг мэдээ, мэдээллээр ханган ажилласан.
- Тус газар болон дүүргийн улсын бүртгэлийн хэлтсүүд мэдээ, мэдээллийг шинэчлэн өөрсдийн Нүүр ном /FACEBOOK/ хуудсанд нийт 452 удаа давхардсан тоогоор оруулсан бөгөөд нийт 758469 харилцагч зочилж, улсын бүртгэлийн хууль тогтоомж, үйлчилгээ, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг авсан байна. Мөн тус газраас хийж байршуулсан 83 мэдээ мэдээлэл, богино хэмжээний видео бичлэгийг 396879 харилцагч давхардсан тоогоор үзсэн байна. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын “Нийслэлийн мэдээ” (356,025 дагагчтай) нүүр хуудсанд үндэсний энгийн цахим гадаад паспортын тухай, улсын бүртгэлийн үйлчилгээний цэгүүдийн газрын зурагтай байршил, албан ёсны хаяг, холбогдох утасны дугаар зэрэг 6 удаагийн постер бэлтгэн байршуулав. Мөн Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын ашигладаг “Ulaanbaatar.erp” системд дээрх мэдээллүүдийг байршуулж ажиллав.
- Reels буюу зурган мэдээлэл 12 удаа – 39092
- Сонгуультай холбоотой мэдээлэл видео бичлэг болон постер 25 удаа – 39652
- И-Монголиа портал сайттай холбоотой бичлэг болон постер 13 удаа – 9548



- Улсын бүртгэлийн үйлчилгээний цахим машинтай холбоотой видео бичлэг болон постер 9 удаа – 11363



- Шинээр байгуулагдсан улсын бүртгэлийн үйлчилгээний цэгийг сурталчлах видео бичлэг болон постер 8 удаа – 31245



- Улсын бүртгэлийн үйлчилгээтэй холбоотой видео бичлэг болон постер 40 удаа – 86297





Мэдээ мэдээлэл

- Цахимаар үйлчилгээний хөлс төлөх талаар 5 удаа – 8662

- Нийслэлд Улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлж буй цэг 34 удаа – 99546
- Бүртгэлийн үйлчилгээний талаар 47 удаа – 47015
- Аян 40 удаа – 19617
- Харилцагчийн сэтгэл ханамжийн судалгаа 6 удаа – 2547
- Сургалтын талаар 15 удаа – 8638



ЦЭГ	УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЦЭГ	ХАРИУЦАГЧИЙН АЖИЛЛАГАА	УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЦЭГ
1	"УХА ТӨИРҮҮ" үйлчилгээний цэг	09:00-18:00	09:00-18:00
2	Сүхбаатар дүүрэг, 9 хороо, Их тэвүүр худалдааны төвний дамжарт	09:00-18:00	09:00-18:00
3	"БҮЙНГ УХАА" үйлчилгээний цэг	09:00-17:00	09:00-17:00
4	Хан-Уул дүүрэг, 21 дугаар хороо, Буюу-Уула ОУУБ	09:00-17:00	09:00-17:00



• “Ёслолтой бүртгэл”-ийн чиглэлээр:

Иргэний баримт бичгийг ёслолтой гардуулж, байгууллагын үйл ажиллагааг сурталчилан ажиллах хүрээнд дүүргийн улсын бүртгэлийн хэлтсүүд 10 удаа “Ёслолтой бүртгэл” арга хэмжээ зохион байгуулж, 58 хосын гэрлэсний бүртгэлд 283 харилцагч оролцож, шинэ төрсөн 101 хүүхдийн төрсний гэрчилгээг, мөн гал

голомтоо бадраан шинээр орон сууцанд орж буй залуу хосод эд хөрөнгийн эрхийн өмчлөх гэрчилгээг ёслол төгөлдөр гардуулж, улсын бүртгэлийн үйл ажиллагаа болон бүртгэлийн байгууллагыг сурталчилсан байна.



- **Нээлттэй хаалганы өдөрлөг:**

Тайлангийн хугацаанд тус газар болон дүүргийн улсын бүртгэлийн хэлтсүүдээс 35 удаагийн нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж иргэн, эд хөрөнгийн эрхийн болон хуулийн этгээдэд улсын бүртгэлийн үйлчилгээг 2212 иргэн, хуулийн этгээдэд үзүүлж нийт 3382 харилцагч нарт мэдээ, мэдээлэл өгч ажилласан.



- **Иргэний андгай өргөх ёслол:**

Баянзүрх дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс нь Монгол Улс анхдугаар Үндсэн хуулиа баталж, Бүгд Найрамдах Улс тунхагласны 100 жилийн ойг тохиолдуулан “Монгол Улсын иргэний андгай өргөх ёслол”-ыг Нийслэлийн ерөнхий боловсролын 85 дугаар сургуулийн урлаг танхимд зохион байгуулсан.

Ёслолын арга хэмжээнд 16 нас хүрч иргэний үнэмлэхээ авах өсвөр үеийн залуусаас нийгэмд хөгжил, оролцоогоороо түүчээлж буй 50 хүүхэд иргэний андгай өргөж, батламж гардан авлаа.



Чингэлтэй дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс нь улс тунхагласан өдрийг тохиолдуулан жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ АНДГАЙ ӨРГӨХ” ёслолын үйл ажиллагааг Нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Боловсролын хэлтэстэй хамтран 11 дүгээр сарын 19-ний өдөр үйлдвэрчний соёлын төв өргөөнд амжилттай зохион байгууллаа. 2024 онд 16 нас хүрч иргэний үнэмлэх анх удаа авах эрх үүссэн Чингэлтэй дүүргийн 2000 иргэн иргэний үнэмлэхээ гардан авч “Монгол Улсын иргэний андгай” өргөлөө. Уг ёслолын үеэр дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн дарга Д.Оюунбилэг оролцогчдод улсын бүртгэлийн тухай хууль тогтоомжийг сурталчлан, иргэний үнэмлэхийн дүрмийг танилцуулгаас гадна 56 иргэнд тоон гарын үсэг олгож 120 иргэнд зөвлөгөө өгч хууль тогтоомжийг сурталчилж ажиллалаа.



2.11.2 Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал:

Энэ хүрээнд <https://www.niislel@burtgel.gov.mn> байгууллагын цахим хуудаст хүний нөөцийн ил тод байдалтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, Байгууллагын бүтэц, орон тоог баталсан тушаал, баталсан орон тоонд ажиллаж байгаа албан хаагчдын мэдээлэл, албан хаагчдад сахилгын шийтгэл ногдуулсан тухай тушаал, албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам, албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм, хүний нөөцтэй холбоотой мэдээ, мэдээллийг тухай бүр байршуулан ажиллаж байна.

2.11.3 Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдал:

Тус байгууллагын шилэн дансанд /<https://www.niislel@burtgel.gov.mn/> нийт 139 мэдээллийг байршуулсан. Мөн газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг байршуулан ажиллаж байна.

2.11.4 Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод байдал:

Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээллийг тухай бүр шинэчлэн байршуулж хэвшсэн.

2.11.5 Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал:

Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилсан байдал, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг байгууллагын албан ёсны сайтад байршуулсан.

2.11.6 Улсын бүртгэлийн байгууллагын “Үйлчилгээний стандарт”-ын хэрэгжилтийг хангах, мэргэжил арга зүйгээр хангах чиг үүргийн хүрээнд:

Нэгжүүдэд улсын бүртгэлийн үйлчилгээг тасралтгүй, түргэн шуурхай хүргэх ажлыг хэрхэн зохион байгуулж байгаа, тулгамдаж буй асуудал, мөн “Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандарт”-ын хэрэгжилт зэрэг ажлын хүрээнд 2024 оны 2 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд Нийслэлийн төвийн 6 дүүргийн НҮНТ (6), улсын бүртгэлийн үйлчилгээний цэг (12), 2024 оны 8 дугаар сарын 7-ны өдөр Хан-Уул дүүргийн Мишээл төв, Баянзүрх дүүргийн Жанжин, Сүхбаатар дүүргийн Их тойруу зэрэг нэгжүүдэд ажиллаж, нэгжийн удирдлагуудад үүрэг, чиглэл өгөв. Түүнчлэн нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдэд ажиллаж байгаа албан хаагчдын шаардлагатай тоног төхөөрөмж, үйлчилгээний танхимын агааржуулалтын систем, тулгамдаж буй асуудлын талаарх санал, хүсэлтийг удирдлагуудад албан бичгээр уламжлав.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны 1/10187 дугаар чиглэлийн дагуу дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн дарга нар нэгдсэн үйлчилгээний төв, цэгүүдэд улсын бүртгэгч нарын ажиллах хуваарийг баталж, тойргийн системээр ажлуулж байна.



Дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсүүдээс байгууллагын үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангах, өдөр тутмын хяналт тавих, тайлагнах зэрэг чиг үүргийг тухайн нэгжийн хэлтсийн дарга, улсын ахлах бүртгэгч нар хэрэгжүүлж, сар бүр НУБГ_СТ_1 маягтаар хэрэгжилтийг дүгнэж, тус хэлтэст ирүүлснийг нэгтгэн дүгнэж ажиллалаа. Үйлчилгээний стандартын хэрэгжилт 92.6 хувийн үзүүлэлттэй байна.

Харилцагчийн үнэлгээний систем нэвтрүүлж, үр дүнг тооцох чиглэлээр:

Албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх, ажлын бүтээмж болон гүйцэтгэл, мэргэшлийн төвшинг үнэлэх зорилгоор үйлчилгээ үзүүлж буй албан хаагч нэг бүрийн цонхонд “Албан хаагчдын хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ авах” QR кодыг байршуулан харилцагчдаас үнэлгээ болон санал хүсэлт авч, ажиллаж байна.

2024 оны байдлаар 1538 харилцагч үнэлгээ өгсөн байна. Үнэлгээ өгсөн байдлыг авч үзвэл дүүргийн УБХ – 1284, НҮНТ – 91, үйлчилгээний цэг 163.

График 1. Үнэлгээ өгсөн нэгжээр:






График 2. Хэлтсийн хэмжээнд:



“Албан хаагчдын хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ авах” асуулгыг хялбаршуулж 3 асуулгын хүрээнд авдаг болж хялбарчилсан.

Харилцагчдаас албан хаагчдын хандлага, ёс зүй, ур чадварт 92% нь сайн, 3% нь дунд, 5% нь муу гэсэн үнэлгээ өгсөн байна.

Албан хаагчдын хандлага, ёс зүй, ур чадварт өгсөн үнэлгээний мэдээлэл, санал, шүүмжийг хэлтсийн дарга нарт хүргүүлж, холбогдох зохион байгуулалтыг хийх чиглэл өгөв.

Байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгаа:

Улсын бүртгэлийн нэгжүүдээс үзүүлж буй улсын бүртгэлийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, нэгжийн зохион байгуулалтын бүтцэд дүгнэлт хийх, хүнд сурталгүй шуурхай байгаа эсэх, албан хаагчдын харилцаа хандлагыг дүгнэх зорилгоор харилцагчийн сэтгэл ханамжийн судалгааг <https://forms.gle/QLy3885Jtohhe6dw7>, QR код үүсгэн тус газрын цахим хуудас, веб сайт, дүүргийн улсын бүртгэлийн хэлтсүүдийн цахим хуудсуудад байршуулж, 2024 оны 10 дугаар сарын 4-ний өдрөөс 11 дүгээр сарын 4-ний өдрийг дуустал цахимаар авав. Судалгаанд 410 харилцагч хамрагдсан. Танд улсын бүртгэлийн цахим үйлчилгээг ямар сувгаар авахад дөхөм байдаг талаар асуухад 74.6 хувь нь e-mongolia, e-business, 14.9 хувь нь цахим машин, 10.4 хувь нь цахим үйлчилгээний төв гэж хариулсан байна. Судалгааны нэгдсэн тайланг гаргаж, дүгнэлт хийж ажиллав. Улсын бүртгэлийн цахим машины талаар 5 удаагийн постер бэлтгэн, тогтмол сурталчлан ажиллаж байна.

“Жендэрийн эрх тэгш байдлыг хангах” чиглэлээр албан хаагчдаас Ажлын байрны бэлгийн дарамт, бусад дарам шахалт байгаа эсэхийг тодруулж, урьдчилан сэргийлэх чиглэлээр санал асуулга авсан. Судалгаанд 172 албан хаагч оролцсон. Таныг хүсээгүй байхад бэлгийн шинжтэй үйлдэл илэрхийлж байсан уу гэсэн асуултад 97.7 хувь /168/ үгүй, 2,3 хувь /4/ тийм гэсэн хариулт өгсөн байна.

ГУРАВ.УЛСЫН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг 2024 оны 11 дүгээр сарын 15-ны байдлаар нийслэлийн хэмжээнд нийт 1108237 иргэн, хуулийн этгээдэд үзүүлсэн байна.

3.1.Иргэний улсын бүртгэл хөтлөх чиглэлээр 813078 иргэнд иргэний бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн байна. Үүнд:

- ❖ Төрсний бүртгэл- 26259
- ❖ Гэрлэсний бүртгэл-6534
- ❖ Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл-2404
- ❖ Үрчилсний бүртгэл-488
- ❖ Овог, эцэг эх –ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэл-1629
- ❖ Нас барсны бүртгэл-8198
- ❖ Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл-77155
- ❖ Иргэний үнэмлэхний бүртгэл-27837
- ❖ Эцэг, эх тогтоосны бүртгэл-1013
- ❖ Үндэсний энгийн гадаад паспорт олголт-8128
- ❖ Үндэсний цахим гадаад паспорт олголт-240371
- ❖ Лавлагаа олголт-288917

❖ Шилжилт хөдөлгөөн-124145

3.2.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх чиглэлээр 237471 эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн байна. Үүнд:

- ❖ Анхны бүртгэл-33776
- ❖ Өмчлөх эрх шилжих гэрээ-52825
- ❖ Барьцааны гэрээ-132470
- ❖ Бусад гэрээ-818
- ❖ Бүртгэлд өөрчлөлт оруулах-9104
- ❖ Лавлагаа, хуулбар-7040
- ❖ Урьдчилсан тэмдэглэл-1429
- ❖ Бусад-9

3.3.Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх чиглэлээр 57688 хуулийн этгээдийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн байна.

3.4.Зөөврийн тоног төхөөрөмж ашиглан улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүллээ.

Улсын бүртгэлийн зөөврийн тоног төхөөрөмжөөр 6310 улсын бүртгэлийг хөтөлж, иргэн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлсэн байна. Тухайлбал:

Багануур дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс нь улсын бүртгэлийн үйлчилгээг тэгш хүртээмжтэйгээр хүргэх зорилгоор улсын бүртгэлийн зөөврийн тоног төхөөрөмжөөр биеэр болон цахим хэлбэрээр авах боломжгүй зорилтот бүлгийн иргэнд “Малчны хотонд” нь, хүнд өвчтэй, өндөр настай 1 иргэн, хөгжлийн бэрхшээлтэй 1 иргэний гэрт нь очиж иргэний шинэчилсэн бүртгэлд хамруулж, хүнд өвчтэй, өндөр настай 1 иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг Эрүүл мэндийн төвд очиж бүртгэсэн байна. Мөн дүүргийн Засаг даргын тамгын газар, Хаан банк, Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газар, дүүргийн ахмадын хороо, Хилийн цэргийн 0252 анги, Шүүхийн Шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харъяа 427 дугаар нээлттэй, хаалттай хорих анги, Боловсрол цогцолбор сургуулийн сурагчид зэрэг нийт 237 иргэнд зөөврийн тоног төхөөрөмжөөр иргэний үнэмлэх, шинэчилсэн бүртгэл, хуулийн этгээдийн нэр баталгаажуулах, тоон гарын үсэг олгож ажилласан байна.



Багахангай дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс нь Төв аймгийн Баян сумын нутаг дэвсгэрт байрлах Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа нээлттэй, хаалттай 415-р хорих анги, Архидан согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар, ШШГЕГ-ын харьяа Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын албан хаагч, хүмүүжигч, эмчлүүлэгч зэрэг нийт 50 иргэнд зөврийн тоног төхөөрөмжөөр үндэсний энгийн цахим гадаад паспорт, иргэний үнэмлэхний болон гэрлэлтийн бүртгэл, тоон гарын үсэг олгож ажилласан байна.



Налайх дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс нь “Алслагдсан 6 дугаар хороо”, “Засаг даргын явуулын өрөө-Нээлттэй хаалганы өдөрлөг”, “Цэрэг татлага” болон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй, зорилтод бүлгийн зэрэг иргэдэд зөврийн тоног төхөөрөмжөөр 63 иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн байна.

Баянгол дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс нь улсын бүртгэлийн зөврийн тоног төхөөрөмжөөр 12 удаа нээлттэй хаалганы өдөрлөгийн үеэр 1880 улсын бүртгэлийг хөтөлж, иргэн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлсэн байна.

Баянзүрх дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс нь улсын бүртгэлийн зөврийн тоног төхөөрөмжөөр 548 улсын бүртгэлийг хөтөлж, иргэн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлсэн байна. Тухайлбал: Баянзүрх дүүргийн 26 дугаар хорооны галд өртсөн 207 дугаар байрны оршин суугч 145 иргэнд хөдөлгөөнт үйлчилгээний зөврийн тоног төхөөрөмжөөр улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж иргэний үнэмлэх, төрсний болон гэрлэлтийн гэрчилгээ, тоон гарын үсэг, цахим үнэмлэхийн лавлагаа эд хөрөнгийн эрхийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагааг үнэ төлбөргүй олгосон. Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Сургалт, хүмүүжлийн тусгай анги, 407, 409, 427, 441 дүгээр хорих ангиудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн байна.



Сонгинохайрхан дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог дэмжих, хөгжүүлэх, бие даан амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг бичиг баримтжуулах, тоон гарын үсэгт хамруулах ажлын хүрээнд дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, ЗДТГ, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс, Нийгмийн даатгал, Боловсролын хэлтэс, Гэр бүл хүүхэд залуучуудын хэлтэстэй хамтарч хөгжлийн бэрхшээлтэй иргэд, Хаан банкны Хархорин салбар, дүүргийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтэс, Боловсролын хэлтэстэй хамтарч Ерөнхий боловсролын 105,106,107,121,129,143 дугаар сургуулийн ажилтан албан хаагч, 8,9,10 дугаар ангийн сурагчид, 2024 оны 1, 2 дугаар ээлжийн цэрэг татлагын байр, дүүргийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан "Ахмадаа дээдэлье"-нээлттэй өдөрлөгийн үеэр тус тус зөөврийн тоног төхөөрөмжөөр улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж, нийт 878 иргэнд иргэний үнэмлэх, иргэний үнэмлэхийн лавлагаа, тоон гарын үсэг олгож ажиллажээ.

Сүхбаатар дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс нь зөөврийн тоног төхөөрөмжөөр үйлчилгээ үзүүлэх хуваарь гаргаж, хуваарийн дагуу болон иргэн, аж ахуй нэгжээс ирүүлсэн хүсэлтийн дагуу иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 22 удаагийн 299 иргэнд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр дүүргийн 14 дүгээр хороонд хэрэгжиж байгаа дахин төлөвлөлтийн хүрээнд "Сэлбэ дэд" төвд 894 мэдүүлэг хүлээн авч иргэдэд түргэн шуурхай үйлчилгээ үзүүлсэн байна.

Хан-Уул дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс нь төрийн болон төрийн бус байгууллага, алслагдсан хороодод улсын бүртгэлийн "Явуулын үйлчилгээ"-ээр, Төрийн банкны 4 удаагийн өдөрлөг, 2024 оны I, II ээлжийн цэрэг татлага, Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв, Архивын ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчдад, Хан-Уул дүүргийн харьяа төрийн 7, 10, 15, 18, 26, 32, 63, 130, 160, 163 болон "Гурван тамир" хувийн сургуульд нийт 747 иргэнд иргэний улсын бүртгэлийн үйлчилгээ, 110 хуулийн этгээдийн улсын бүртгэл, 55 иргэнд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ буюу нийт 912 иргэн, хуулийн этгээдэд зөөврийн тоног төхөөрөмжөөр үйлчилгээ үзүүлж, 1520 гаруй иргэнд мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан байна.



Чингэлтэй дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс нь иргэдэд улсын бүртгэлийн хууль тогтоомжийг сурталчлах, төрийн үйлчилгээг түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, иргэнтэй хамтран 13 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, зөөврийн тоног төхөөрөмж ашиглан 549 иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн байна.



3.5 Бичиг баримтжуулах ажлын хүрээнд:

Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн дагуу хэрэгжилтийг хангах болон хаягийн зөрчлийг арилгах, бичиг баримтгүй иргэдийг бичиг баримтжуулах зорилгоор “Иргэний бичиг баримтын зөрчил арилгах” аяныг 2024 оны 1 дүгээр сарын 17-ны өдрөөс 2 дугаар сарын 17-ны өдрийг хүртэлх 1 сарын хугацаанд зохион байгуулав.

Аяны хугацаанд дүүргүүдийн улсын бүртгэгч, хорооны Засаг дарга, хэсгийн ахлагч нарын бүрэлдэхүүнтэйгээр хорооны хүн амын судалгаанд тулгуурлан иргэний улсын бүртгэлийн мэдээллийн цахим сантай тулгалт хийж ажилласан ба Нийслэлийн 9 дүүргийн 204 хороодод бүртгэлтэй 1700666 иргэн хамрагдахаас 339929 иргэн буюу 30 хувь нь хамрагдсан байна.

Аяны үр дүнд илэрсэн зөрчлийн мөрөөр хаягийн бүртгэлийн зөрчлийг арилгах арга хэмжээг холбогдох газруудтай хамтран зохион байгуулж ажилласан. Үүнд:

- Бичиг баримтжуулсан иргэн 241 буюу 70.3 хувь
- Бичиг баримтын зөрчил арилгуулсан иргэн 2953 буюу 85.9 хувь
- 0-16 насны иргэдийг хаягийн бүртгэлд хамруулсан 3117 буюу 98.7 хувь
- Дахин төлөвлөлтөд орж хаягийн хөдөлгөөн хийгдсэн 737 иргэний зөрчил буюу 14.5 хувийг тус тус арилгуулсан.

Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу шилжилт хөдөлгөөний бүртгэлийн зөрчилтэй 8 иргэдийн хаягийг хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр улсын бүртгэлийн мэдээллийн санд түдгэлзүүлсэн байна.

Мөн ёслолтой бүртгэл, тоон гарын үсэг олгох ажлыг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж, 55 ёслолтой бүртгэл, 3394 иргэнд тоон гарын үсэг олгосон.

Шинээр байгуулагдсан хороодын хаягийн бүртгэл солигдсон 85 иргэний хаягийн бүртгэлийг мэдээллийн санд тусгаж, хаягжуулсан байна.

Илэрсэн зөрчлүүдийг арилгуулах чиглэлээр Багануур 88.5 хувь, Багахангай 74.3 хувь, Баянгол 74.4 хувь, Баянзүрх 98.4 хувь, Налайх 6.1 хувь, Сонгинохайрхан 100 хувь, Сүхбаатар 17.5 хувь, Хан-Уул 4.9 хувь, Чингэлтэй 76 хувийн гүйцэтгэлтэй тус тус ажилласан.

Аяны хугацаанд бүртгэлийн нийт 12004 иргэний зөрчлийг илрүүлснээс 7141 иргэний буюу 60 хувийн зөрчлийг арилгуулсан байна.



3.6. Улсын бүртгэлийн нэгдсэн архивын чиглэлээр:

Баримт нягтлан шалгах арга зүйн комисс (БНШАЗК)-ын хурлын шийдвэр, тус газрын даргын “Хадгалах хугацаа дууссан баримтыг устгах тухай” 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн А/06 тушаалаар ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нийслэл, дүүрэг тус бүр байгуулж, хадгалах хугацаа дууссан 1.065 хадгаламжийн нэгж, 799 бүртгэлийн дэвтэр, 63.634 ширхэг ИУБ маягт, 9.215 хураагдаж хүчингүй болсон баримт бичиг, нийт 480.486 хуудас иргэн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн баримтыг нягтлан шалгалт хийж, аюулгүй байдлыг ханган, устгах ажлыг зохион байгуулсан. Устгал хийсэн тухай илтгэх хуудсыг БНШАЗК-д хүргүүлсэн.

Тус газрын иргэний баримтын архив, байгууллагын архив, албан хаагчдын ажлын өрөөнд 2024 оны 4 сард хортон шавж устгал, архивын сан хөмрөгийн ил задгай цахилгааны утас, гэрлийг сольж, шинэчилж засуулсан.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын нэгдсэн архивын байран дахь төвийн 6 дүүргийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын сан хөмрөгт бүртгэлийг хөтлөх талаар үүрэг өгч, хяналт тавин ажиллаж байна.

9 дүүргийн улсын бүртгэлийн архивын нөхцөл, хадгалалт хамгаалалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн судалгаа гарган, дүн шинжилгээ хийж, холбогдох саналаа Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлсэн.

“Өмч хамгаалах байнгын зөвлөл”-д ахлах мэргэжилтэн, ахлах архивч нар гишүүнээр ажиллаж, үндсэн хөрөнгийн тооллого, акталж устгах ажилд хөндлөнгийн хяналт тавьж ажиллаж байна. 2024 оны хагас жилийн эд хөрөнгийн тооллогын дүнгээр цаашид ашиглах боломжгүй болсон актлах шаардлагатай 501 ширхэг 461,718,709.94 төгрөгийн үнийн дүнтэй үндсэн хөрөнгийг актлах асуудлыг хэлэлцэн актлах шийдвэрийг гарган Нийслэлийн өмчийн харилцааны газарт хурлын тэмдэглэл болон хурлаас гарсан шийдвэрийн хамт хүргүүлж ажиллалаа.

Иргэний улсын бүртгэлийн архивын чиглэлээр:

2023 онд хөтлөгдсөн бүртгэлийн эх нотлох баримтыг хуваарийн дагуу нийслэлийн дүүргүүд, төв, цэгүүдээс эх нотлох баримтын нийт 547 боть, хяналтын улсын байцаагчийн дүгнэлт, дүгнэлтийн эх нотлох 52 боть, бүртгэлийн дэвтэр 30 ширхгийг хүлээн авч он цаг, бүртгэлийн төрлөөр нь хадгаламжийн нэгж болгон архивын хадгаламжийн санд байрлуулсан.

Нийслэлийн улсын бүртгэлийн төв, цэгүүд дээр хөтлөгдсөн иргэний улсын бүртгэлийн ИУБ маягтын 10 төрлийн 145.490ш “Б” тал, Улсын бүртгэлийн ерөнхий газрын иргэний бүртгэлийн газраас гадаад улс дах консул, элчин сайдын яамдад

бүртгэсэн 10.075 ИУБ маягтын “Б” тал, орон нутгийн улсын бүртгэлийн хэлтсээс нийт 38.969 иргэний хувийн хэргийг тус тус хүлээн авсан. 151.158 ИУБ маягтыг цагаан толгойн үсгийн дарааллаар галиглан, архивын сан хөмрөгт 141.129 ИУБ маягтуудыг холбогдох хадгаламжийн санд байрлуулаад байна. 36.955 ИУБ маягтыг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд нягтлан шалгаж, харьяатаас гарсан 14 иргэний хувийн хэргийг харьяатаас гарсны бүртгэлийн, нас барсан 18.746 иргэний хувийн хэргийг нас барсны бүртгэлийн санд тус тус шилжүүлэн байрлуулсан.

Бүртгэлийн зөрчлийг арилгах, мэдээллийн санг цэгцлэх ажлын хүрээнд 75 иргэний, шүүх, хуулийн байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу 61 иргэний бүртгэлийн баримтыг архивын сан хөмрөгөөс шүүж “Хуулбар үнэн” тэмдгээр баталгаажуулан, хариуг хүргүүлсэн.

Аймаг, нийслэлийн улсын бүртгэлийн хэлтсүүдээс ирүүлсэн хэсэлтийн дагуу улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд цахимжаагүй 456 бүртгэлийн нотлох баримтыг архивын сан хөмрөгөөс шүүн, улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд 894 хуудас баримтыг цахимжуулсан.

Нийслэлд харьяалал харгалзахгүй улсын бүртгэлийн үйлчилгээ авсан иргэдийн бүртгэлийн ИУБ маягтын 21.139ш “Б” тал болон орон нутагт шилжин явсан иргэдийн 6.461 хувийн хэргийг харьяалах орон нутаг руу албан бичгээр хүргүүлсэн.

Тус газар, дүүргүүдийн улсын бүртгэлийн хэлтэс, төв, цэгүүдээс иргэний гэр бүлийн байдлын нийт 227.570 лавлагаа, мэдээлэл олгосноос хууль хяналтын байгууллагын хүсэлтээр 12.799, иргэний өөрийн хүсэлтээр 199.046 лавлагааг олгож, бүртгэлийн үйл ажиллагаанд 15.725 лавлагааг албан хэрэгцээнд ашигласан байна.

2024 оны 1 дүгээр сард тус газрын иргэний баримтын архивын сан хөмрөгт хөтлөгдөх баримт ашиглалт, чийг дулаан хэмжих, цэвэрлэгээ, засвар үйлчилгээ, галын хор шалгах тэмдэглэл, бүртгэлийг шинэчлэн баталж хяналт тавьж ажиллаж байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын чиглэлээр:

Нийслэлийн дүүргүүдийн улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивт 29.996 хувийн хэрэг шинээр, 205.383 хувийн хэрэгт бүртгэлийн эх нотлох баримтын баяжилтаар нэмэгдсэн.

Төвийн 6 дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс, нийслэлийн үйлчилгээний нэгдсэн 6 төвд харьяалал харгалзахгүй бүртгэгдсэн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн эх нотлох баримтын баяжилтыг долоо хоногт 2 удаа тээвэрлэж, харьяалах төвийн 6 дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн архивын 35.103 хувийн хэрэгт 351.030 эх нотлох баримтыг шилжүүлэх ажлыг гүйцэтгэсэн.

Нийт 236.738 хувийн хэргийг дүүргүүдийн улсын бүртгэлийн судлаач-архивч нар архивын сан хөмрөгт байрлуулсан байна.

Дүүргүүдийн Улсын бүртгэлийн хэлтсийн архивын сан хөмрөгт байрлах эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн баримтыг 15.565ш зориулалтын цаасан хайрцгаар сольсон.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр:

Тус газрын даргын 2024 оны А/05 дугаар тушаалын дагуу дүүргийн улсын бүртгэлийн хэлтсүүдэд хураагдсан нийт 2.539 ш тамга тэмдгийг хураан авч Улсын

бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын 2024 оны 4/1399 дугаартай чиглэлийн дагуу тамга тэмдгийг ангилан устгахад бэлдээд байна.

Мэргэжил арга зүйгээр хангах чиглэлээр:

9 дүүргийн улсын бүртгэлийн хэлтэст архивын эх нотлох баримтын хадгалалт, хамгаалалтад анхаарах, харьяалал харгалзахгүй бүртгэгдсэн хуулийн этгээд, эд хөрөнгийн улсын бүртгэлийн эх нотлох баримтыг архивт хугацаанд нь шилжүүлэх талаар 2024 оны 1/467 дугаартай албан бичиг, 2, 8 дугаартай дотоод албан бичгээр тус тус чиглэл хүргүүлсэн.

Тус газарт шинээр томилогдсон 18 албан хаагчид “Архивын эх нотлох баримтын тухай ойлголт” сэдэвт сургалтад мэдээлэл хийсэн.

Багануур, Баянгол, Баянзүрх, Налайх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй, Хан-Уул дүүргийн улсын бүртгэлийн хэлтэст очин, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын баримтын хадгалалт хамгаалалтад заавар, зөвлөгөө өгч мэргэжил арга зүйгээр ханган ажилласан.

Хан-Уул дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн архивын хадгаламжийн сангийн нягтруулсан шүүгээ, тавиур дүүрч, шалаар байсан 50.000 хувийн хэргийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын нэгдсэн архивын байр луу нүүлгэн шилжүүлэх ажлыг 2024 оны 3 дугаар сарын 13-ны өдрөөс бэлтгэж, 3 дугаар сарын 16, 17 өдрүүдэд нүүлгэх ажлыг зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр ханган, хяналт тавьсан.

Архивын холбогдолтой хууль, дүрэм журмын гарын авлага гарган, төвийн 6 дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн судлаач-архивч нарт хүргүүлсэн.

Хан-Уул, Сүхбаатар дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын байдлыг танилцуулан, шийдвэрлэх арга хэмжээний саналыг Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлсэн.

Архивын байр, ажилтны үйл ажиллагаанд хориглох зүйлийн талаарх хууль эрх зүйн актаар брошур хийж, хадгаламжийн сан хариуцан ажилладаг 23 албан хаагчдад танилцуулан, Улсын бүртгэлийн нэгдсэн архивын байрны 1, архивын хэлтэс 1, 9 дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн хадгаламжийн санд тус тус байрлуулсан.

ДӨРӨВ. СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ

4.1 Монгол Улсын Их хурлын 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах ажлын хүрээнд:

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Нэг. Бэлтгэл ажлын хүрээнд:

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах үүрэг бүхий Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны А/1712 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэгт тус газраас орж ажилласан. Энэ ажлын хүрээнд 6 бүлэг 112 арга хэмжээ бүхий Монгол Улсын Их хурлын 2024 оны ээлжит

сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө /цаашид “төлөвлөгөө” гэх/ батлагдсан.

Батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 01 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Их хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах цаг хугацааны хуваарь”-тай нийцүүлэн тогтоосон хугацаанд бүрэн хэрэгжүүлж байна.

“Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт, онцлог зохицуулалт” сэдэвт зохион байгуулсан сургалтанд 9 дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн /Багануур-10, Багахангай-4, Баянгол-22, Баянзүрх-39, Налайх-12, Сонгинохайрхан-36, Сүхбаатар-15, Хан-Уул-24, Чингэлтэй-15/ нийт 177 иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга, улсын бүртгэгч нар хамрагдсан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар хороо хариуцан ажиллах улсын бүртгэгчдийн хуваарийг дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн дарга нараар батлуулан Иргэний улсын бүртгэлийн газарт 2024 оны 01 дүгээр сарын 31-ний 1/65 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

“Засаг захиргааны анхан шатны нэгжийн бүтцэд өөрчлөлт орсонтой холбоотойгоор /хороо шинээр байгуулагдсан/ иргэний байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн мэдээллийг шалгаж, илтгэх хуудсыг Хяналт шалгалтын газарт 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр хүргүүлэв.

Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн цахим сан дахь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлтэй сонгуулийн эрх бүхий иргэний тоог хороо бүрээр 2024 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаар гарган дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд албан бичгээр хүргүүлсэн.

Мөн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолыг 2024 оны 2 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн хүлээн авч, нягтлан шалгаж, тогтоолд заасан сонгуулийн хэсгийн нутаг дэвсгэрийн мэдээллийг Иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан дахь сонгогчийн бүртгэлд тусган ажилласан. Энэ ажлын хүрээнд Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 92 дугаар тогтоолд тусгагдаагүй хаяг /байр, гудамж, тоотууд/ байсныг нягтлан шалгаж, тогтоолын хавсралтад өөрчлөлт тусгуулах тухай саналыг холбогдох байгууллагад хүргүүлж ажилласан. Хэсэг оноолт хийх явцад 3000 дээш сонгогч бүртгэгдсэн Баянзүрх дүүргийн 4, 6, 8, 10, 13, 17, 18, 19, 24, 37, 39 хорооны нийт 11 хэсгийн хорооны хаягийг сонгуулийн нэг санал авах байрнаас нөгөө санал авах байранд шилжүүлж, сонгогчдын тоог тэнцүүлэх ажлыг хийж, зөрчлийг арилгаж, хэсэг оноолтыг хийж гүйцэтгэсэн.

Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 01/91 дугаартай тогтоолд тусгагдсан хороодын сонгогчийн дүнг 2024 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн сонгогчийн тоотой тулган шалгахад 11, 17, 19, 23 дугаар хороодын сонгогчийн тоо 11 хэсэгт 3000-аас дээш байгааг холбогдох байгууллагад 2 удаа албан бичгээр санал хүргүүлэн ажиллав.

Сонгуулийн хэсэг байгуулж, хэсгийн нутаг дэвсгэрийг зарласан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолыг 2024 оны 2 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн хүлээн авч эх хувиар Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлсэн.

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолыг нягтлан шалгаж, шивэх явцад гарсан алдааг Иргэний улсын бүртгэлийн газарт албан бичгээр хүсэлт гаргаж залруулга хийлгэж ажиллав.

Сонгуулийн хэсэг байгуулсан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолыг election.gasr.mn программд холбогдох тогтоолын эх хувьтай тулган шалгасан тухай илтгэх хуудсыг Хяналт шалгалтын газарт 2024 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 1/147 дугаар албан бичгээр хүргүүлэв.

Сонгуулийн хэсгийн мэдээлэл, дугаарлалтыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолтой тулган нягтлан шалгаж, зөрчлийг арилгасан.

Сонгуулийн нэг хэсэгт 2700-аас дээш гарсан сонгогчийн тоонд тухай бүр хяналт тавьж ажилласан.

Мөн “Иргэний бичиг баримтын зөрчил арилгах” 1 сарын аяныг зохион байгуулж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан. Энэ арга хэмжээнд 9 дүүргийн 204 хороодод бүртгэлтэй 1700666 иргэн хамрагдахаас 339929 иргэн буюу 30 хувь нь хамрагдсан байна. Үүнээс 12004 иргэний зөрчлийг илрүүлснээс 7141 иргэний буюу 60 хувийн зөрчлийг арилгуулсан. Мөн бичиг баримтгүй 343 иргэнээс 241 иргэнийг бичиг баримтжуулсан.

Хоёр.Сонгогчдын нэрийн жагсаалтыг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд үндэслэн үйлдэх, нягтлан шалгах ажлын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн хэсэг байгуулсан тухай мэдээллийг Иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан дахь тухайн хэсгийн нутаг дэвсгэрт байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэл бүхий сонгогчийн бүртгэлтэй тулган шалгаж, сонгогчийн бүртгэлд бүртгэгдээгүй, сонгуулийн хэсэг оноогдоогүй болон иргэний улсын бүртгэлийн зөрчилтэй иргэний зөрчлийг арилгах, зөрүүтэй оноогдсон сонгогчдын мэдээллийг засварлаж, election.gasr.mn программд сонгуулийн хэсэг оноолтыг өдөр тутам шалган, хэсэг оноолтыг хийж байна.

Сонгогчдын нэрийн жагсаалтыг 4 дүгээр сарын 1-ний өдөр www.burtgel.gov.mn цахим хуудсанд байрлуулж, иргэдийг өөрийн болон байнга оршин суугаа хаягийн бүртгэлд бүртгэгдсэн сонгогчийн мэдээлэлтэй танилцах боломжоор ханган ажилласан.

Мөн 4 дүгээр сарын 26-ны өдрийн 17 цагаар шилжилт хөдөлгөөний бүртгэлийг дуусгавар болгон эцэслэж, бүртгэлийг баталгаажуулан, нотлох баримтыг цахимжуулан ажиллав.

Гурав. Сонгогчийн нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулах, нягтлан шалгах, түүнтэй холбоотой программ хангамж, техник, тоног төхөөрөмж, хүний нөөцийн зардлыг шийдвэрлүүлэх ажлын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

УДШ, ШШГЕГ, ХХЕГ, БХЯ, ЦЕГ-аас ирүүлсэн сонгуулийн насны иргэдийн мэдээлэлд тусгасан нэмэлт тэмдэглэгээг нягтлан шалгаж, зөрчлийг арилгах ажлын хүрээнд дээрх байгууллагуудаас ирүүлсэн сонгуулийн насны иргэдийн мэдээллийг хуулийн хугацаанд хүлээн авч хасав, түр хасав төлөв оноосон.

Сонгуулийн хэсэгт ажиллах итгэмжлэгдсэн ажилтны судалгааг гаргаж, Тагнуулын ерөнхий газарт 12 албан бичгээр 1191 иргэний мэдээлэл хүргүүлж зөвшөөрөл авч газрын даргын 2024 оны Б/29 дугаар тушаалаар дүүргийн хэсгийн хороодод ажиллах итгэмжлэгдсэн ажилтнуудыг томилсон. Энэ талаар Нийслэлийн

боловсролын газарт 2024.04.29-ний 1/251 дугаар “Хамтран ажиллах тухай” албан бичиг хүргүүлсэн.

Сонгуулийн хэсэгт ажиллах итгэмжлэгдсэн ажилтантай гэрээ байгуулж, нууцын баталгаа гаргуулав.

Нийслэл дэх Төрийн аудитын газарт Нийслэлийн дүүргийн хүн амын тоо, сонгуулийн насны хүний тоог хороо, хэсэг тус бүрээр гаргаж хүргүүлэв.

Сонгуулийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллах үүрэг бүхий ажлын хэсэг, дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийг хариуцан ажиллах албан хаагчдыг томилсон.

Дөрөв.Сонгогчийн нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулах, хүргүүлэх, гомдлыг нягтлан шалгахтай холбоотой ажлын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

Нийслэлийн хэмжээнд 2024 оны 5 дугаар сарын 31, 6 дугаар сарын 23-ны өдөр /election.gasr.mn/ цахим сангаас сонгуулийн 513 хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтыг 2 хувь хэвлэж, нийслэлийн сонгуулийн 513 хэсгийн хороонд цаасан хэлбэрээр хүлээлгэн өгсөн.

Иргэний улсын бүртгэлийн газрын 2024 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн 3/7848 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу Нийслэлийн хэмжээнд 2024 оны 6 дугаар сарын 13-ны өдөр сонгогчийн шилжилт хөдөлгөөний бүртгэлийг бүртгэсэн.

Мэдээллийн технологийн газартай хамтран дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн мэдээллийн технологийн ажилтнууд сонгогчийг бүртгэх, таньж оруулах, техник хэрэгсэлд үйлдлийн систем суулгах, мэдээллийн цахим санг хуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Тус газрын даргын баталсан сонгогчийг бүртгэх, таньж оруулах техник хэрэгслийг дүүргийн улсын бүртгэлийн хэлтсүүдэд хүлээлгэн өгөх, хүлээн авах хуваарийн дагуу 2024 оны 6 дугаар сарын 22-ны өдөр тоног төхөөрөмжийг бүрэн гүйцэд хүлээлцсэн.

Дүүргийн улсын бүртгэлийн хэлтсүүдийн улсын бүртгэгч, итгэмжлэгдсэн ажилтнуудад программын болон эрх зүйн сургалт явуулахад бэлтгэл хангасан тухай судалгаа гаргаж, хяналт тавьж ажиллав. 2024 оны 6 дугаар сарын 23-ны өдөр 9 дүүргийн улсын бүртгэлийн хэлтэст программын болон эрх зүйн сургалтыг зохион байгуулж, сургалтанд 316 албан хаагчид, 814 итгэмжлэгдсэн ажилтан хамрагдсан байна.

Тус газрын даргын тушаалаар нийслэлийн дүүргийн улсын бүртгэлийн хэлтсүүдэд хэлтсийн дарга, мэргэжилтнүүд хуваарийн дагуу хяналт тавьж ажилласан.

Тав. Сонгуулийн санал авах өдөр хэрхэн ажилласан талаар:

Сонгуулийн санал авах өдөр буюу 2024 оны 6 дугаар сарын 28-ны өдөр Мэдээллийн технологийн шуурхай багийн 31 гишүүд, тус газрын 17, дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн 349 албан хаагч, Улсын бүртгэлийн байгууллагын 835 итгэмжлэгдсэн ажилтан, нийт 1232 албан хаагч ажиллалаа.

Мэдээллийн технологийн шуурхай багийн гишүүд тоног төхөөрөмж гацсан, хэсгийн дэлгэц хуваагдаж шилжихгүй байгаа, хурууны хээ уншигч төхөөрөмж ажиллахгүй байна гэх мэт дуудлага өгсөн хэсгийн хороогоор дуудлагын дагуу очин зөрчлийг арилган ажиллав.

Тус газрын даргын 2024 оны А/09 дугаар тушаалаар сонгуулийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллах үүрэг бүхий ажлын хэсэг, дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийг хариуцан ажиллах албан хаагчдыг томилж, тогтмол хяналт тавьж ажилласан. Томилогдсон албан хаагчид хуваарийн дагуу сонгуулийн санал авах өдөр тус газар болон дүүргийн улсын бүртгэлийн хэлтсүүдэд ажиллалаа. Тус газарт ажилласан албан хаагчид сонгогчийн ирцийн мэдээг програмаар хяналт тавьж, мэдээг тухай бүр илгээх, илгээгээгүй хэсгийн сонгогчийн мэдээллийг байнга харж, тулгалт хийж, дүүргийн улсын бүртгэлийн хэлтэст ажиллаж буй ажлын хэсгийн гишүүдийг тухай бүр мэдээллээр хангаж ажилласан. Мөн тус газрын байранд Сонгуулийн ерөнхий хорооноос зөвшөөрсний дагуу сонгуулийн хэсгийн хороодод байрлуулсан камерыг байршуулж уг тулгалтын үйл ажиллагаанд хамт уялдуулж ажилласан.

Дүүргийн улсын бүртгэлийн хэлтсүүд нь сонгуулийн санал авах өдөр гомдол гаргасан иргэний мэдээллийг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд шалган хариу өгч, сонгуулийн санал авах өдрийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэж ажилласан. Итгэмжлэгдсэн ажилтнуудад заавар, чиглэл өгч сонгуулийн ирцийн мэдээг байнга илгээж, илгээгдээгүй байгаа хэсгийн хороодын итгэмжлэгдсэн ажилтнуудтай утсаар холбогдож, илгээж ажилласан. Мөн иргэний улсын бүртгэгч нар итгэмжлэгдсэн ажилтан нарт /election.gasr.mn/ цахим сангаас сонгогчийн хаягийг шүүж нэн даруй мэдээлэл солилцож ажилласан.

Баянгол дүүргийн 9-1-31-2 дугаар сонгуулийн хэсэгт програмд техникийн саатал гарч 3 цаг сонгуулийн санал авах үйл ажиллагаа зогссон. Мэдээлэл технологийн газрын холбогдох ажилтнууд ирж саатлыг засварласан. Техникийн саатлын улмаас тухайн хэсгийн хорооны сонгогчдод бухимдал үүссэн боловч хэвийн болж ирц нь 67,97 хувиар хангалттай хүрсэн. Мөн Нэгүн.мн гэх хэвлэл мэдээллийн байгууллага 15-22 цагийн хооронд Баянгол дүүргийн улсын бүртгэлийн хэлтсээс намаар нь ялгаварлан хаягаас нь хасч байна гэх гүтгэлгийн шинж чанартай лайв хийж бэрхшээл учруулж байсан.

Сонгуулийн санал авах өдрийн үйл ажиллагаа 2024 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн өглөөний 07.00 цагт эхэлж, 22:00 цагт дууслаа.

Нийт хэсгийн хороодоос сервер компьютер, клиент компьютер, хэвлэх төхөөрөмж бусад дагалдах хэрэгслийг акт үйлдэн хүлээн авч лацдаж, нөөц техник, тоног, төхөөрөмжийн хамт хэлтсийн байранд зөөн байршуулан цагдаагийн байгууллагын хамгаалалтанд авсан.

Зургаа. Бусад ажлын хүрээнд:

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2024 оны А/45 дугаар захирамжийн дагуу Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд ашиглах сонгуулийн автоматжуулах хэрэгслийн програм хангамж, иж бүрдлийг шалган турших үйл ажиллагааг 2024 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 12:00 цагт зохион байгуулсан. Энэхүү туршилтын явцад гарсан алдааг Мэдээллийн технологийн газарт мэдэгдэж, засварлаж ажилласан.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн А/109 дугаар “Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, шуурхай баг ажиллуулах тухай” тушаалаар батлагдсан Мэдээллийн технологийн шуурхай багийн бүрэлдэхүүнд 9 дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн мэдээллийн

технологийн ажилтнууд орж 2024 оны 6 дугаар сарын 27-ны өдөр сонгуулийн хэсгийн хороодоор явж, сонгуулийн үйл ажиллагаанд ашиглагдах техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг ханган ажиллаж, сонгуулийн санал авах өдөр буюу 2024 оны 6 дугаар сарын 28-ны өдөр улсын бүртгэлийн хэлтсүүдэд дуудлагын дагуу ажилласан.

Сонгогчийг бүртгэх, таньж оруулах техник хэрэгслийг хүлээлгэн өгөх хуваарийн дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газарт 2024 оны 6 дугаар сарын 29-ний өдөр тоног төхөөрөмжийг бүрэн гүйцэд хүлээлгэн өгсөн.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн бэлтгэл ажлыг хуулийн хугацаанд бүрэн гүйцэтгэж, сонгуулийн үйл ажиллагаа нийслэлийн хэмжээнд 70 хувьтай хэвийн явагдаж амжилттай дууслаа.

4.2 Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах ажлын хүрээнд:

Бэлтгэл ажлын хүрээнд:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэгт тус газраас орж ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд 5 бүлэг 71 арга хэмжээ бүхий Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө батлагдсан.

Уг төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг Сонгуулийн ерөнхий хорооны баталсан “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах цаг хугацааны хуваарь”-тай нийцүүлэн тогтоосон хугацаанд бүрэн хэрэгжүүлж байна.

Мөн тус газрын даргын 2024 оны А/23 дугаар “Зохион байгуулалтын арга хэмжээ авах, ажлын хэсэг байгуулах тухай” тушаалаар Сонгуулийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллах үүрэг бүхий ажлын хэсэг, дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийг хариуцан ажиллах албан хаагчдыг томилж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Төлөвлөгөөний дагуу иргэний улсын бүртгэлийн мэдээллийн цахим сан дахь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлтэй сонгуулийн эрх бүхий иргэний тоог хороо тус бүрээр гарган тухайн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд албан бичгээр хүргүүлсэн.

Сонгуулийн хэсгийн мэдээлэл, дугаарлалтыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолтой тулган нягтлан шалгаж, зөрчлийг арилгасан.

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн хэсэг байгуулсан тухай мэдээллийг Иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан дахь тухайн хэсгийн нутаг дэвсгэрт байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэл бүхий сонгогчийн бүртгэлтэй тулган шалгаж, сонгогчийн бүртгэлд бүртгэгдээгүй, сонгуулийн хэсэг оноогдоогүй болон иргэний улсын бүртгэлийн зөрчилтэй иргэний зөрчлийг арилгах, зөрүүтэй оноогдсон сонгогчдын мэдээллийг засварлаж, election.gasr.mn программд сонгуулийн хэсэг оноолтыг өдөр тутам шалган, хэсэг оноолтыг хийсэн. Мөн гомдол гаргасан иргэний мэдээллийг шалгаж, иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд үндэслэн лавлагаа хэвлэж ажилласан.

Сонгогчдын нэрийн жагсаалтыг 7 дугаар сарын 13-ны өдөр www.burtgel.gov.mn цахим хуудсанд байрлуулж, иргэдийг өөрийн болон байнга оршин суугаа хаягийн бүртгэлд бүртгэгдсэн сонгогчийн мэдээлэлтэй танилцах боломжоор ханган ажиллалаа.

Мөн 8 дугаар сарын 12-ны өдрийн 17 цагаар иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг дуусгавар болгон эцэслэж, бүртгэлийг баталгаажуулан, нотлох баримтыг цахимжуулан ажиллав.

Нийслэлийн хэмжээнд 2024 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр election.gasr.mn/ цахим сангаас сонгуулийн 515 хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтыг 2 хувь хэвлэж, нийслэлийн сонгуулийн 515 хэсгийн хороонд цаасан хэлбэрээр хүлээлгэн өгсөн.

Сонгуулийн хэсэгт ажиллах итгэмжлэгдсэн ажилтны судалгааг гаргаж, Тагнуулын ерөнхий газарт 16 удаагийн албан бичгээр 1129 иргэний мэдээлэл хүргүүлж зөвшөөрөл авч газрын даргын 2024 оны Б/57 дугаар тушаалаар дүүргийн хэсгийн хороодод ажиллах итгэмжлэгдсэн ажилтнуудыг томилсон.

Сонгуулийн хэсэгт ажиллах итгэмжлэгдсэн ажилтантай гэрээ байгуулж, нууцын баталгаа гаргуулав.

Нийслэлийн боловсролын газарт 2024 оны 8 дүгээр сарын 12-ны өдрийн 2/506 дугаар “Хамтран ажиллах тухай” албан бичиг хүргүүлсэн.

Нийслэлийн сонгуулийн хороонд нийслэлийн сонгуулийн хэсгийн хороо, санал авах байр, сонгогчийн тоог хэсэг тус бүрээр гаргаж 2 удаа хүргүүлэв.

Тус газрын дарга Нийслэлийн сонгуулийн хорооноос зохион байгуулсан нийслэл, дүүргийн сонгуулийн хороод болон бусад холбогдох мэргэжлийн байгууллагуудын хамтарсан нэгдсэн сургалт, уулзалтанд оролцож, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг хууль тогтоомжид заасан чиг үүргийн хүрээнд зохион байгуулж, хэрэгжүүлж байгаа тухай мэдээлэл хийсэн.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль-ийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх үйл ажиллагаа болон сонгогчдын нэрийн жагсаалттай танилцах, ашиглах журам”, “Итгэмжлэгдсэн ажилтантай гэрээ байгуулах”, “Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудал”, “Төрийн болон албаны нууцын тухай хууль” зэрэг сэдвүүдээр улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан нарт зориулсан 9 удаагийн сургалтыг зохион байгуулсан байна. Тус сургалтад 406 итгэмжлэгдсэн ажилтан, албан хаагчид хамрагдсан байна.

Дүүргийн улсын бүртгэлийн хэлтсүүдийн улсын бүртгэгч, итгэмжлэгдсэн ажилтнуудад программын болон эрх зүйн сургалтыг 2024 оны 10 дугаар сарын 6-ны өдөр зохион байгуулсан. Тус газрын даргын тушаалаар нийслэлийн дүүргийн улсын бүртгэлийн хэлтсүүдэд хэлтсийн дарга, мэргэжилтнүүд хуваарийн дагуу хяналт тавьж ажилласан.

Мэдээллийн технологийн газартай хамтран дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн мэдээллийн технологийн ажилтнууд сонгогчийг бүртгэх, таньж оруулах, техник хэрэгсэлд үйлдлийн систем суулгах, мэдээллийн цахим санг хуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Тус газрын даргын баталсан сонгогчийг бүртгэх, таньж оруулах техник хэрэгслийг дүүргийн улсын бүртгэлийн хэлтсүүдэд хүлээлгэн өгөх, хүлээн авах

хуваарийн дагуу 2024 оны 10 дугаар сарын 6-ны өдөр тоног төхөөрөмжийг бүрэн гүйцэд хүлээлцсэн.

Сонгуулийн санал авах өдөр хэрхэн ажилласан талаар:

Сонгуулийн санал авах өдөр буюу 2024 оны 10 дугаар сарын 11-ний өдөр Мэдээллийн технологийн шуурхай багийн гишүүд, тус газар болон дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчид, улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнууд ажиллалаа.

Мэдээллийн технологийн шуурхай багийн гишүүд тоног төхөөрөмж гацсан, хэсгийн дэлгэц хуваагдаж шилжихгүй байгаа, хурууны хээ уншигч төхөөрөмж ажиллахгүй байна гэх мэт дуудлага өгсөн хэсгийн хороогоор дуудлагын дагуу очин зөрчлийг арилган ажиллав.

Тус газрын даргын 2024 оны А/23 дугаар тушаалаар сонгуулийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллах үүрэг бүхий ажлын хэсэг, дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийг хариуцан ажиллах албан хаагчдыг томилж, тогтмол хяналт тавьж ажилласан. Томилогдсон албан хаагчид хуваарийн дагуу сонгуулийн санал авах өдөр тус газар болон дүүргийн улсын бүртгэлийн хэлтсүүдэд ажиллалаа. Тус газарт ажилласан албан хаагчид сонгогчийн ирцийн мэдээг програмаар хяналт тавьж, мэдээг тухай бүр илгээх, илгээгээгүй хэсгийн сонгогчийн мэдээллийг байнга харж, тулгалт хийж, дүүргийн улсын бүртгэлийн хэлтэст ажиллаж буй ажлын хэсгийн гишүүдийг тухай бүр мэдээллээр хангаж ажилласан. Мөн тус газрын байранд Сонгуулийн ерөнхий хорооноос зөвшөөрсний дагуу сонгуулийн хэсгийн хороодод байрлуулсан камерыг байршуулж уг тулгалтын үйл ажиллагаанд хамт уялдуулж ажилласан.

Дүүргийн улсын бүртгэлийн хэлтсүүд нь сонгуулийн санал авах өдөр гомдол гаргасан иргэний мэдээллийг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд шалган хариу өгч, сонгуулийн санал авах өдрийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэж ажилласан. Итгэмжлэгдсэн ажилтнуудад заавар, чиглэл өгч сонгуулийн ирцийн мэдээг байнга илгээж, илгээгдээгүй байгаа хэсгийн хороодын итгэмжлэгдсэн ажилтнуудтай утсаар холбогдож, илгээж ажилласан. Мөн иргэний улсын бүртгэгч нар итгэмжлэгдсэн ажилтан нарт /election.gasr.mn/ цахим сангаас сонгогчийн хаягийг шүүж нэн даруй мэдээлэл солилцож ажилласан.

Сонгуулийн санал авах өдрийн үйл ажиллагаа 2024 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн өглөөний 07.00 цагт эхэлж, 20:00 цагт дууслаа.

Нийт хэсгийн хороодоос компьютер, хэвлэх төхөөрөмж бусад дагалдах хэрэгслийг акт үйлдэн хүлээн авч лацдаж, нөөц техник, тоног, төхөөрөмжийн хамт хэлтсийн байранд зөөн байршуулан цагдаагийн байгууллагын хамгаалалтанд авсан.

Сонгогчийг бүртгэх, таньж оруулах техник хэрэгслийг хүлээлгэн өгөх хуваарийн дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газарт 2024 оны 10 дугаар сарын 12-ны өдөр тоног төхөөрөмжийг бүрэн гүйцэд хүлээлгэн өгсөн.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн бэлтгэл ажлыг хуулийн хугацаанд бүрэн гүйцэтгэж, сонгуулийн үйл ажиллагаа нийслэлийн хэмжээнд 42.3 хувьтай хэвийн явагдаж амжилттай дууслаа.

ТАВ. ЗОХИОН БАЙГУУЛСАН БУСАД АЖИЛ

5.1. Зарлан мэдээллийн дохиогоор ажилласан тухай

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, “Гамшгийн үеийн дайчилгаа, нүүлгэн шилжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах нэгдсэн дадлага, сургуульд 2024 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 16.00 цагт оролцов.

Уг дадлага сургуулийн талаарх мэдээллийг бүх хэлтсүүдэд хүргүүлж, дадлага сургуулилтад бэлтгэл бэлэн байдлыг хангаж оролцсон.

Тус дадлага сургуульд нийслэлийн Онцгой байдлын газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтсийн мэргэжилтэн Н.Отгонцэцэг хяналт тавьж үүрэг гүйцэтгэлээ.



5.2. “Цэвэрлэгээний өдөр” арга хэмжээг зохион байгуулсан тухай

Баянзүрх дүүргийн Засаг даргын 2024 оны А/68 дугаар захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2024 оны 02 дугаар сарын 6-ны өдөр орчны 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газрын хог хаягдал, цас мөсийг цэвэрлэх цэвэрлэгээний ажлыг зохион байгуулан оролцож, холбогдох газарт илтгэх хуудсыг хүргүүлсэн.

- Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/348 дугаар захирамж, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр баталсан “Хаврын бүх нийтийн их цэвэрлэгээ арга хэмжээг зохион байгуулах тухай” удирдамжид заасан хуваарийн дагуу 2024 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 14.00 цагаас 15.30 цаг хүртэл төвийн 3 хэлтсийн 18 албан хаагч, төвийн 6 дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн төрийн үйлчилгээний 24 албан хаагч, нийт 42 албан хаагч уг арга хэмжээнд оролцлоо.

Уг цэвэрлэгээний хуваарийн дагуу тус газрын албан хаагчид Олимпын гудамж, Гадаад хэргийн яамны уулзвараас Замын цагдаагийн уулзвар хүртэлх нийтийн эзэмшлийн зам талбайд цэвэрлэлээ хийлээ. 21 шуудай хог хаягдал гарсан болно.



Бүх нийтийн цэвэрлэгээнд нэгдсэн тухай мэдээллийг газрын цахим хуудас болон 24tsag.mn мэдээллийн сайтаар сурталчилан ажилласан.

- Улаанбаатар хотын ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны даргын баталсан “Бүх нийтийн цэвэрлэгээ” арга хэмжээний удирдамжийн дагуу нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, гуу жалганд үүссэн хог хаягдлыг цэвэрлэх хуваарийн дагуу 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдөр Зуун айлын гүүрнээс урагш Е-Мартын гүүр хүртэл голын баруун талын хэсгийг тус байгууллагын нийт албан хаагч цэвэрлэлээ.



5.3. “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн” зохион байгуулсан тухай

Монгол Улсын ерөнхийлөгчийн “Мод тарих үндэсний өдөр, Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ий хүрээнд 2024 оны хаврын мод тарих арга хэмжээг “Ногоон хот-Иргэний оролцоо”, “Арчлахгүй бол Ургахгүй” уриатай зохион байгуулсан.

Уг үйл ажиллагаанд тус газрын хамт олон идэвхитэй оролцож, 2024 оны 5 дугаар сарын 10-ны өдөр 200 ш хайлаас модыг Налайх дүүргийн 7 дугаар хороо, “Шинэ Налайх цэцэрлэгт хүрээлэн”-д суулгасан. Мөн өнгөрсөн жилийн суулгасан моднуудын арчилгаа усалгаа хийсэн.

Тус арга хэмжээний хүрээнд Баянгол дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс 15ш хайлаас 131 дүгээр сургуульд, Сонгинохайрхан дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс 40ш хайлаас, улиас мод Цагдаа толгойд, Чингэлтэй дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс 5ш монос мод Хайрхан хөгжлийн төвд, Налайх дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс 68ш хайлаас мод “Шинэ налайх цэцэрлэгт хүрээлэнд, нийт 328ш мод тарьсан. Мөн Багануур дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчдын цуглуулсан 130.000 төгрөгийг энэ ажилд зориулан шилжүүлсэн.



Хан-Уул дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчид Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Айцын аманд хэрэгжүүлж буй ойжуулалтын талбайд 2022-2023 онд суулгасан 50 модны суурь тогоонд ургасан шарилж зэрлэгийн түүж, цэвэрлэн, усжуулав.



Мөн 1 ширхэг суулгац 10,000 төгрөг бүхий 20 буйлс модны суулгацыг худалдан авсан ба өмнөх жилүүдэд тарьсан боловч ургаагүй 15 модыг сэлгэж байрлуулав.

Чингэлтэй дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс нь 2024 оны намрын мод тариалалтаар ажлын орчны агаарын чанарыг сайжруулж хүчилтөрөгч хамгийн их ялгаруулдаг 5 төрлийн ургамал 100 ширхэг, Чингэлтэй хайрхандаа шинэс, хайлаас 2 төрлийн мод 200 ширхгийг тус тус тарилаа.




5.4. Бусад ажил


- Тус газар нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 11/16 дугаар “Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх тухай” удирдамжийн дагуу Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын 2023 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн шалгалтаар “Хангалттай” үнэлгээ авсан.

- Өвөлжилт хүндэрсэн аймгийн малчдад гамшгийн гарз хохирол багатай даван туулах сэтгэлийн дэм хандивын “Бүртгэлийн илч” аянд газрын нийт албан хаагчид идэвхтэй оролцож, 3.835.500 төгрөгийн хандив өргөсөн.

- Жендэрийн үндэсний хорооноос санаачлан хэрэгжүүлж буй "Харилцан хүндэтгэе" сарын аянд нийслэл, дүүргийн улсын бүртгэлийн газар, хэлтсийн хамт олон нэгдэж, оролцлоо. Аяны хүрээнд “ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЭ” нэртэйгээр "Харилцан хүндэтгэж, тэгш оролцоог хангая" уриан дор оролцон нөлөөллийн ажлыг амжилттай зохион байгуулан хэлтсүүдийн цахим /FACEBOOK/ хуудсанд нийт 3, байгууллагын веб хуудсанд 1, ep.ulaanbaatar.mn системд 1 удаа давхардсан тоогоор 5 мэдээ, мэдээлэл оруулсан ба 6120 харилцагч эдгээр хуудсуудад зочилж, аяны талаарх постер мэдээ, мэдээллийг үзсэн байна.



Ажилтан албан хаагчдад Жендэр, жендэрийн эрх тэгш байдлын талаарх ойлголт, жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалт, хүчирхийллийн тухай ойлголт хандлагыг нэмэгдүүлэх талаар мэдээ, мэдээлэл өгч ажиллав.



- Тус газраас албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих, хөдөлмөрийн явцад бий болсон ядралыг сэргээх, ажлын чадварыг нэмэгдүүлэн улмаар хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх үүднээс өдөр тутам дасгал хөдөлгөөнийг тогтмол хийж эхэлсэн.

- Баянзүрх дүүргийн улсын бүртгэлийн хэлтсээс зохион байгуулж байгаа цэгүүдийн албан хаагч нартай 7 хоног бүрийн Мягмар гарагийн өглөө 07:30 минутанд Төр захиргааны 2 дугаар байр, Жанжин, Жуков нэг цэгүүдэд "Эртэч өглөө" уулзалтыг зохион байгууллаа.



Тус уулзалтад улсын бүртгэлийн цэгийн үйлчилгээний байршилд харъяалагдах 9,34,17,16,40,22,32,19,24 дүгээр хороодын Засаг дарга нарыг урьж бүртгэлийн үйлчилгээний өдөр тутмын ажил, мөн сонгуулийн бэлтгэл ажлыг хангах талаар ярилцаж, санал солилцон хоорондоо нэгдсэн нэг ойлголт авах, бүртгэлийн үйлчилгээний талаарх чиглэлүүд, нэгж дээрх тулгамдаж буй асуудлын талаар нээлттэй ярилцаж харилцан санал солилцлоо.

- Чингэлтэй дүүргийн улсын бүртгэлийн хэлтсээс Чингэлтэй дүүргийн Хайрхан хөгжил 1 төвд хэлтсийн албан хаагчдаас бүрдсэн холимог 6 багийн тамирчид ширээний теннис, волейбол, дартс зэрэг спортын 3 төрлөөр өрсөлдөж, хурд хүч, авхаалж самбаагаа сорьж шилдгүүдээ тодрууллаа. Энэ удаагийн спорт тэмцээний нэг онцлог нь нийт албан хаагчид хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлж, ажлын байрны дасгал хөдөлгөөн хийж сурцгаалаа.



Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчид эрүүл, идэвхтэй амьдралыг эрхэмлэн хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлж дасгал хөдөлгөөнийг хэвшил болгох зорилго тавьж хамт олноороо аэробикийн дасгал хийж сурсан ба цаашид ажлын байранд дасгал хөдөлгөөн тогтмол хийх, гүйлт, дугуй, иога, алхалт гэх мэт улирлын онцлогт тохирсон спортоор албан хаагчдыг тогтмол хичээллэхэд нь дэмжлэг үзүүлж хэлтсийн “Спортын баг”-аас олон төрлийн арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Хамт олноороо сурсан эхний дасгалаа Чингэлтэй хайрханы өвөрт байрлах хөл бөмбөгийн задгай ногоон талбайд хийж дүрсжүүлсэн.

- Сонгинохайрхан дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн хамт олон амралт чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, албан хаагчдын эрүүл аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлж хамт олны дунд “Шилжин явах” цомын төлөөх гар бөмбөгийн нөхөрсөг тэмцээнийг жил болгон зохион байгуулдаг уламжлалтай. Энэ оны 5 дугаар сарын 3-ны өдөр хамт олны дунд гар бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулж шилдэгүүдээ тодруулсан.



- Налайх дүүргийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн “Гудамж талбайд нийтийн хэв журам сахиулах эргүүл ажиллуулах тухай” А/14 дүгээр захирамжийн дагуу хэлтсийн 16 албан хаагч дүүргийн 1,2,3,7,8 дугаар хорооны нутаг дэвсгэрт 5 удаа эргүүл хийсэн.

- Улсын бүртгэлийн байгууллагын түүхт 84, бүртгэлийн тогтолцоонд шилжсэний 15 жилийн ой “Улсын бүртгэлийн ажилтны өдөр”-ийг угтан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн хүрээнд ажилтан, албан хаагчдыг идэвхижүүлэх, ажлын байр, өрөө тасалгааг цэцэгжүүлэх, тохижуулах ажилчдын идэвхи оролцоо ханган “Ногоон нэгж” нэгдсэн аяны хүрээнд албан өрөө, албан хаагчдын ширээг цэцэгжүүлж зураг контент хийж холбогдох газарт хүргүүлж албан хаагчдад танилцуулж, хэрэгжилтийг ханган ажилласан.



- Улсын бүртгэлийн ажилтны өдрийг угтан тус газрын албан хаагчдын дунд спортын 3 төрөлт тэмцээнийг зохион байгуулж, “Шилжин явах цом”-ыг тэргүүн байр эзэлсэн Сонгинохайрхан дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс хүлээлгэн өгсөн.



ЗУРГАА. САНАЛ

1. Тус газар нь Монгол банкны байрыг түрээслэн үйл ажиллагаа явуулдаг. Монгол банкнаас түрээсийн төлбөрийг нэмэх талаар албан бичиг ирүүлсэн. Энэ талаар 2025 оны төсөвт саналаа хүргүүлсэн тул түрээсийн төлбөрийг шийдвэрлэж өгөх;
2. Хүний нөөцийн томилгоо удаан хийгдэж байгаа нь 1 улсын бүртгэгч 2-3 улсын бүртгэгчийн ажлыг орлон гүйцэтгэх эрсдэл үүсэж, ажлын ачаалал нэмэгдэж байна. Иймд улсын бүртгэгчийг тогтвор, суурьшилтай ажиллуулах чиглэлээр бодлогын арга хэмжээнүүдийг шат дараалалтай авч хэрэгжүүлэх;
3. Төсвийн зарцуулалтын 97.2% цалин хөлс, байр ашиглалт 0.5%, хангамжийн зардал 1.76%, урсгал засвар 0.18%, бусдаар гүйцэтгүүлсэн ажил 0.13%, нэг удаагийн тэтгэмж 0.07% байгаа нь албан хаагчдын нийгмийн асуудал хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллуулах, сургах ажлыг зохион байгуулахад санхүүгийн хүрэлцээгүй байдал нь хүндрэлтэй байдаг тул 2025

- оны төсөвт ажилтан, албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, дэмжлэг үзүүлэх, мөнгөн буцалтгүй тусламж олгох, санхүүжилтийг шийдвэрлэж, нэмэгдүүлэх;
4. Улсын бүртгэгч нарын албан хэрэгцээнд ашиглаж байгаа компьютер, тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа дуусч, дахин үнэлж ашиглаж байгаа тул шинэчлэх;
 5. Бичиг хэргийн зардлын төсвийг 2025-2027 оны төсвийн төсөлд хүргүүлсэн тул үүний дагуу бичиг хэргийн зардлыг нэмэгдүүлэх;
 6. Дүүргүүдийн Улсын бүртгэлийн хэлтсийн архивын сан хөмрөгт байрлах эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн баримтыг зориулалтын цаасан хайрцгаар солих ажил хийгдэж байна. Гэтэл шинээр ирж буй цаасан хайрцаг нь нягтруулсан шүүгээний тавцан хооронд өндөрдөж хэмжээ нь тохирохгүй, материал нь муу, чанарын шаардлага хангахгүй байх тул чанарын шаардлага хангасан зориулалтын хайрцгаар хангах;
 7. Тус газрын архив, 6 дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн архивын сан хөмрөгийн нягтруулсан шүүгээнд засвар хийх санхүүжилтийг шийдвэрлэх /Улсын бүртгэлийн ерөнхий газарт албан бичиг хүргүүлсэн/;
 8. Сүхбаатар дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивт бороо хур ихтэй үед хөрсний ус нэвтрэн ордог тул бүртгэлийн эх нотлох баримтыг гэмтэх, устах эрсдэлтэй, мөн Баянзүрх, Чингэлтэй дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн архивын хадгаламжийн сан зай талбайгүй болсны улмаас архивын эх нотлох баримтыг шалаар байрлуулж эхэлсэн, хадгаламжийн сан автомашины гараж, подвалд байрлаж байгаа нь гал, усны өндөр эрсдэлтэй байна. Иймд улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9 дүгээр зүйлд “Улсын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан төрийн өмч, улсын онцгой объектын зэрэглэлтэй байна” гэж заасны дагуу дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн, тус газрын иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримтыг хадгалах архивын зориулалтын барилгыг цогцоор шийдүүлэх саналтай байна.

ТАНИЛЦСАН:
ДАРГА

Г.АНХНЫБАЯР

ХЯНАСАН:
ЗАХИРГАА УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.БАЙГАЛМАА

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ш.НАРАНЦАЦРАЛ